

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
2009 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

**Эрүүл мэндийн салбарт:**

Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2009 оны 360 дугаар тушаалаар 2010 оны өвлийн, 2012 оны зуны олимпийн наадамд оролцох Монгол Улсын баг тамирчдын бэлтгэл хангах ажлын хүрээнд “Банкувер-2010”, “Лондон-2012” хөтөлбөрийг тус тус баталж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр боловсруулж ажиллахыг БТС-ын газрын даргад, хяналт тавьж ажиллах, шаардагдах зардлыг биеийн тамир, спортын төвлөрсөн арга хэмжээний зардалд тусгах замаар санхүүжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг жил бүрийн 12 сард багтаан хийж, сайдын зөвлөлд танилцуулж байхыг холбогдох албан тушаалтнуудад даалгав.

Томуугийн А хүрээний (H1N1) вирусийн цартахлын үед үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор Засгийн газрын хөрөнгөөр худалдан авсан 515,4 сая төгрөгийн үнэ бүхий 20 ширхэг амьсгалын аппаратыг Эрүүл мэндийн сайдын 2009 оны 366 дугаар тушаалаар Орхон, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг болон нийслэлийн нэгдсэн эмнэлгүүдэд хуваарилан олгов. Мөн Эрүүл мэндийн сайдын 2009 оны 369 дүгээр тушаалаар томуугийн вирусийн халдварын үед хэрэглэх эмийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эм, эмнэлгийн хэрэгслийг зарим эмнэлэг болон бусад байгууллагуудад хуваарилан олгож, эдгээр эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисыг орлогод авч, хяналттай зарцуулахыг орон нутгийн эрүүл мэндийн газрын болон бүх эмнэлгийн байгууллага, бусад байгууллагын дарга, захирал нарт даалгав.

Засгийн газрын 2009.11.09-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн томуугийн А хүрээний (H1N1) вирусийн халдварын цартахалд жирэмсэн эмэгтэй хэт эрсдэлтэй байгааг тэмдэглээд Эрүүл мэндийн сайдын 2009 оны 370 дугаар тушаалаар *“Томуугийн А хүрээний (H1N1) вирусийн халдварын сэжигтэй болон халдвар авсан жирэмсэн эмэгтэйн хяналт, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж”* зөвлөмжийг баталж, эх барихын тусламжид нэн шаардлагатай байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх, мэдээлэл сургалт сурталчилгаа явуулах ажлын жагсаалтыг гаргаж, дайчлагдан ажиллах эмч, мэргэжилтний томилолт, урамшуулал, замын зардал болон шаардагдах бусад төсвийг тооцож 2009.11.15-ны дотор шийдвэрлүүлэх, олон улсын байгууллагаас нэмэлт санхүүжилт олохыг холбогдох албан тушаалтнуудад даалгав.

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн бүтцэд *“Хор судлалын төв”* байгуулсантай холбогдуулан Засгийн газрын 2008 оны 98 дугаар тогтоолын дагуу худалдан авсан 71,2 сая төгрөгийн үнэ бүхий багаж хэрэгсэл, компьютер, лабораторийн тоног төхөөрөмж, шил сав, бодис урвалжийг Эрүүл мэндийн сайдын 2009 оны 371 дүгээр тушаалаар НЭМХ-д олгож, эдгээрийг үндсэн хөрөнгийн бүртгэлд авч, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг тус хүрээлэнгийн захиралд, хор судлалын төвийн цалингийн эх үүсвэрийг Эрүүл мэндийн сайдын багцад багтаан шийдвэрлэхийг Санхүү хөрөнгө оруулалтын газарт үүрэг болгов.

Засгийн газрын 2008 оны 25 дугаар тогтоол, Засгийн газрын 2009.11.04-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн улс орон даяар 14 хоногийн өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 248/149/372 тоот хамтарсан тушаалаар *“Хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах түр журам”*, хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тус тус баталжээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2009 оны 104 дүгээр захирамжаар байгуулагдсан Засгийн газрын ажлын хэсгийн 2009.11.11-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2009 оны 373 дугаар тушаалаар томуугийн А хүрээний (H1N1) вирусийн халдвар, томуу, томуу төст өвчний тархалтын үед эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудад хандаж эмчийн үзлэг хийлгэх, зөвлөгөө авахыг хүссэн хүн бүрт эрүүл мэндийн даатгал, иргэний бүртгэл, харьяалал харгалзахгүйгээр тусламж, үйлчилгээ шуурхай үзүүлэхийг өрх, тосгон, сум, сум дунд, аймаг, дүүргийн эмнэлгийн удирдлага, нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад үүрэг болгов.

Хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламжийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2009 оны 375 дугаар тушаалаар *“Эрүүл мэндийн салбарын хөгжил-2”* төслийн хүрээнд нийлүүлсэн 484,5 мянган ам.долларын үнэ бүхий автомашиныг нэр бүхий 17 аймагт олгож, эдгээр автомашиныг үндсэн хөрөнгийн бүртгэлд авч, зориулалтын дагуу ашиглахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгов.

2007 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, эрүүл мэндийн чиглэлээр бакалаврын болон мэргэжлийн боловсрол олгох сургалтын тогтолцоог эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлоготой уялдуулах зорилгоор Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 377/486 дугаар хамтарсан тушаалаар эрүүл мэндийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хамтарсан дүгнэлт, санал гаргах Байнгын комиссыг 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн болон бакалавр, магистр, докторын түвшний сургалт эрхлэх байгууллага байгуулах, шинэ мэргэжил нээх, мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагын элсэлтийн хяналтын тоог тогтоох, Эрүүл мэндийн шинжлэх ухааны чиглэлээр эзэмшүүлэх мэргэжлийн чиглэл, индекс тогтоох, шинэчлэх, эрүүл мэндийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг сургалтын байгууллагыг аттестатчилах болон мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлаар хамтарсан дүгнэлт, санал гаргаж байхаар шийдвэрлэв. Мөн хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 378/484 дугаар хамтарсан тушаалаар Эрүүл мэндийн бакалаврын боловсролын стандарт боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг 31 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар батлав.

Томуугийн А хүрээний (H1N1) вирусийн халдварын тархалтыг хязгаарлах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2009 оны 379 дүгээр тушаалаар томуугийн мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлын хэсгийг Эрүүл мэндийн дэд сайдаар ахлуулан 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж, материалыг хэвлүүлэх, тараах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэгт даалгав.

- Томуугийн А хүрээний (H1N1) вирусийн цартахлын үед үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор Засгийн газрын хөрөнгөөр худалдан авсан 463,3 сая төгрөгийн үнэ бүхий сэхээн амьдруулах тасгийн тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн сайдын 2009 оны 382 дугаар тушаалаар клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргүүдийн эмнэлгүүдэд хуваарилж, эдгээрийг үндсэн хөрөнгийн бүртгэлд авч зориулалтын дагуу ашиглахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгов.
- Хөрөнгө гаргах тухай Засгийн газрын 2009 оны 139 дүгээр тогтоолыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2009 оны 390 дүгээр тушаалаар томуугийн цартахлын А хүрээний (H1N1) вирусийн халдварын үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хуваарилан олгож, Зөвлөх баг болон бусад байгууллагад олгох хуваарь болон Онцгой байдлын ерөнхий газраас олгосон зайнаас халуун хэмжигчийн хуваарийг тус тус баталж, хуваарилсан эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисыг орлогод авч хяналттай зарцуулахыг холбогдох албан тушаалтнуудад даалгав.
- Томуугийн цартахлын А хүрээний (H1N1) вирусийн халдвартай тэмцэх, сэргийлэх хариу арга хэмжээг хангах зорилгоор Эрүүл мэндийн сайдын болон Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 396/426 дугаар хамтарсан тушаалаар халдварын эсрэг вакциныг шуурхай түгээх, дархлаажуулах төлөвлөгөөг баталж, ДЭМБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу томуугийн цартахлын (H1N1) вирусийн халдварын эсрэг вакцинаар уг төлөвлөгөөний дагуу дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын төв, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нарт даалгав.
- Томуугийн цартахлын (H1N1) вирусийн халдварын үед эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2009 оны 403 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад А хүрээний (H1N1) вирусийн халдварын чиглэлээр мэргэжлийн зөвлөгөөг цаг алдалгүй өгөх, зайн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжүүдийг суурилуулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн дэд сайдаар ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажлын хэсгийн удирдамжийг батлан мөрдүүлэв.
- Томуугийн А хүрээний (H1N1) вирусийн халдварт өртөх эрсдэл бүхий бага насны хүүхдүүдийн биеийн эсэргүүцлийг сайжруулах, “Эх, хүүхдийн бичил тэжээлийн дутлаас сэргийлэх стратеги”ийг хэрэгжүүлэх зорилгоор “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын санхүүжилтээр нийлүүлсэн 28,2 сая төгрөгийн үнэ бүхий олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг 6-17 сартай хүүхдэд түгээх хуваарийг Эрүүл мэндийн сайдын 2009 оны 410 дугаар тушаалаар баталж, хавсралтын дагуу олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг түгээх, түгээлтийн тайланг мэдээлэх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар, олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн талаарх мэдээлэл, сургалт сурталчилгаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Хоол судлалын төв, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газарт тус тус даалгав.

БЗДХ/ХДХВ-ийн тархалтын харуулдан тандалтын судалгааны ажлыг улс орон даяар зохион байгуулахтай холбогдуулан **Эрүүл мэндийн сайдын 2009 оны 380 дугаар тушаалаар харуулдан тандалтын судалгааны удирдах зөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, судалгааг 2009 онд багтаан явуулж үр дүнг Эрүүл мэндийн сайдын зөвлөлд танилцуулахыг Удирдах зөвлөлд даалгав.**

Эрүүл мэндийн тухай хуулийн 34.1 дэх заалт болон “Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үндэсний стратеги”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2009 оны 397 дугаар тушаалаар Сүрьеэгийн тусламж үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтын заавар, Эмэнд мэдрэг сүрьеэгийн тусламж үйлчилгээний удирдамж, Сүрьеэ, ХДХВ-ийн хавсарсан халдварын тусламж, үйлчилгээний удирдамж, Сүрьеэгийн эм, урвалж бодисын менежментийн удирдамж, Сүрьеэгийн тархвар судлал, халдвар хяналтын арга хэмжээний удирдамж, Хяналт-шинжилгээ% үнэлгээний удирдамж, Сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх үйл ажиллагааны удирдамжийг тус тус баталж, эмэнд дасалтай сүрьеэгийн өвчтөнг хэвтүүлэн эмчлэх 2-5 ортой 1-2 өрөөг халдвар хяналтын дэглэмийн дагуу батлагдсан төсөвтөө багтаан 2010 оны 1 дүгээр сараас зохион байгуулж, 2011 оноос орон нутгийн төсөвтөө тусган тогтвортой ажиллуулахыг Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн дарга нарт, эмэнд дасалтай сүрьеэгийн тасгийг батлагдсан орон тоондоо багтаан халдвар хамгааллын дэглэмийн дагуу 60 ортой болгон 2010 оны 1 дүгээр сараас өргөжүүлэн ажиллуулахыг ХӨСТ-д тус тус даалгав. Мөн Улаанбаатар хотын орон гэргүй, тэнэмэл, оршин суух тодорхой хаяггүй иргэдэд сүрьеэгийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор 2011 оны 1 дүгээр сараас улсын төсөвт тусган “Энэрэл” эмнэлэгт 16 ор бүхий сүрьеэгийн тасгийг тогтвортой ажиллуулахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгов.

“Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний гуравдахь хөтөлбөрийн 2.3 дахь зорилт, “Эхийн эндэгдлийг бууруулах стратеги”-ийн 2 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор **Эрүүл мэндийн сайдын 2009 оны 405 дугаар тушаалаар ДЭМБ-тай хамтран хамтран хэрэгжүүлж буй “Аюулгүй жирэмслэлт” төслийн шугамаар захиалан нийлүүлэгдэж буй 45,3 сая төгрөгийн үнэ бүхий багаж, тоног төхөөрөмжийг Дархан-Уул, Орхон, Өмнөговь, Сүхбаатар аймаг болон нөөцөд хуваарилж, тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн бүртгэлд авч ашиглалтад хяналт тавьж ажиллахыг тухайн аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгажээ.**

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12.1 дэх заалтыг үндэслэн **Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 407/265/159 дүгээр хамтарсан тушаалаар улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгээр санхүүжүүлэх хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг хавсралтаар баталж, 2010.01.01-ний өдрөөс мөрдөхөөр шийдвэрлэв.**

Биеийн тамир, спортын тухай хуулийн 20,3 дахь заалт, Сангийн сайдын 2009 оны 3-4/4848 тоот саналыг үндэслэн **Эрүүл мэндийн сайдын 2009 оны 385 дугаар тушаалаар Улаанбаатар хотноо 2009.10.31-11.01-ний өдрүүдэд зохиогдсон “Чингис хаан-2009” жудо бөхийн Дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээний төсвийг 110,0 сая төгрөгөөр батлав.**

Азийн хөгжлийн банк /АХБ/-ны буцалтгүй тусламжаар хэрэгжих “Бага насны хүүхдийн хоол тэжээлийн архаг дутлыг бууруулах” төслийг хэрэгжүүлэхээр байгуулсан гэрээг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2009 оны 411 дүгээр тушаалаар төслийн зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх байгууллага, зөвлөхүүдийн нээлттэй сонгон шалгаруулалт явуулах ажлын хэсгийг ЭМЯ-ны газрын даргаар ахлуулан 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажил үүргийн хуваарийг батлан мөрдүүлэв.

Монгол Улсад улсад ажиллаж байгаа Олон улсын байгууллагын тэргүүнүүдтэй Эрүүл мэндийн дэд сайд уулзаж, манайд оронд гараад байгаа хүний томуугийн цартахлын А хүрээний Н1Н1 вирусийн халдварын байдал, түүний тархалтыг зогсоох талаар ЭМЯ-наас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар танилцуулж, цаашид шаардлагатай байгаа тусламж, дэмжлэгийн талаар мэдээлэл хийж, санал бодлоо солилцлоо. Уг уулзалтад **ДЭМБ, НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн сан, Дэлхийн банк, Азийн Хөгжлийн Банк, Олон улсын Улаан Загалмайн Нийгэмлэг, Мянганы сорилтын сангийн төлөөлөгчид оролцож, уулзалтын үр дүнд манай улсын хүний томуугийн цартахлын А/Н1Н1/ вирусийн халдвартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээнд зориулж ойролцоогоор 1,5 сая ам.долларын тусламж үзүүлж, төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэхээр боллоо.**

АНУ-ын “Флагстафф интернейшнл релиф эфпорт” төрийн бус байгууллага, Монгол Улсын ЭМЯ хооронд хамтран ажиллах гэрээнд Эрүүл мэндийн дэд сайд, тус төрийн бус байгууллагын төлөөлөгч Мередит Поттс нар 2009.11.24-ний өдөр гарын үсэг зурлаа. Гэрээний дагуу АНУ-ын “Флагстафф интернейшнл релиф эфпорт” төрийн бус байгууллага Монгол Улсын эрүүл мэндийн салбарт эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд цусаар дамжих халдварын тархалтын талаар судалгаа явуулж, эмнэлгийн ажилтнуудыг гепатит Б вирусын вакцинжуулалтад хамруулах, Гэмтэл согог сэргээн заслын эрдэм шинжилгээний төв болон хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад гэмтэл согог заслын нөөц чадавхийг бэхжүүлэх, эмнэлгийн хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх, мэдлэг мэдээллийг дээшүүлэх талаар шинэ туршлага нэвтрүүлэх ажлыг хийх юм.

Хүний томуугийн цар тахлын А хүрээний H1N1 вирусын халдвар нэлээд тархаж, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд илүү өртөж, өвчлөл, хүндрэл гарч байгаа билээ. Иймд хүн амын эрсдэлт бүлэг болох жирэмсэн эмэгтэйчүүдэд зориулж тэднийг энэ халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар авсан эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламжийг сайжруулахад НҮБ-ын Хүн амын сангаас 100 гаруй сая төгрөгийн тусламж, дэмжлэгийг Монгол Улсын Засгийн газарт үзүүлэхээр боллоо. Энэ хүрээнд НҮБ-ын Хүн амын сангаас манай нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 5 орчим хувьд хүрэлцэхүйц 60 сая төгрөгийн өртөг бүхий Тамифлу эм, халдвар аваад хүндэрсэн эхчүүдийг эмчлэхэд зориулж 10,2 сая төгрөгийн өртөг бүхий Цефазолин, Цефтриаксон гэсэн хоёр төрлийн антибиотик, томуугийн цартахлын А хүрээний H1N1 вирусын халдвараас урьдчилан сэргийлэхэд зориулсан мэдээлэл сургалт сурталчилгаанд зориулж 11 сая төгрөг, хөдөө орон нутагт ажиллах нарийн мэргэжлийн эмч нарын баг ажиллах зардалд 14 сая төгрөгийг тус тус олгосныг 2009 оны арваннэгдүгээр сарын 16-ны өдөр НҮБ-ын Хүн амын сангийн Суурин төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэгч Эрүүл мэндийн дэд сайдад гардуулж өглөө. Мөн хөдөөгийн эмнэлгүүдийн төрөх тасгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 2009 оны эхэнд аймгуудаас захиалга авсан бөгөөд өнөөдрийн байдлаар ирээд байгаа өвчтөний монитор 14, зүрхний бичлэгийн аппарат 15, нийтдээ 51,9 сая төгрөгийн өртөг бүхий багаж тоног төхөөрөмжийг Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Хэнтий, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Төв аймгуудад энэ үеэр гардуулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2009 оны 104 дүгээр захирамжаар байгуулагдсан Засгийн газрын ажлын хэсгийн 2009.11.03-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн томуугийн цартахлын А хүрээний (H1N1) вирусийн халдварын тархалтын үед хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2009 оны 363 дугаар тушаалаар хүндэрсэн өвчтөнг хэвтүүлэн эмчлэх зорилгоор УКТЭ, П.Н.Шастины нэрэмжит төв эмнэлэг, ЭНЭШТ, Нялхсын клиник сувилал, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Ачтан-элит эмнэлгийн орыг 25-100-аар нэмэгдүүлж ажиллуулахыг эмнэлгийн дарга нарт үүрэг болгож, уг халдварын улмаас дүүргийн эмнэлэг, ЭМТ-дэд хэвтэн эмчлүүлж байгаа, үйлчлүүлэхээр ирсэн, хүндэрсэн өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгүүдийн харьяалах дүүргийн хуваарийг баталж, тогтсон оюутны хотхонуудад вирүсийн халдвараас сэргийлэх, хянах үзлэгийн хэсгийг байгуулан үйл ажиллагааг нь зохицуулж ажиллахыг ЭМШУИС-ийн захиралд даалгав. Дээрхи вирүсийн халдварын тархалтын үед эрүүл мэндийн байгууллагуудад мөрдөх халдвар хамгааллын дэглэмийг сайжруулах, эмч, ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2009 оны 364 дүгээр тушаалаар уг вирүсийн халдвар, томуу, ТТӨ-ний тархалтын үед эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын дотоод халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөх, хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмч, ажилчдынхаа эрүүл мэндийг дэмжих, халдвар авахаас сэргийлэх, дархлааг сайжруулах, витаминжуулах, томуугаас урьдчилан сэргийлэх боломжтой хүнсний зүйлээр хангах асуудлыг өөрийн төсвийн хүрээнд зохицуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эмнэлэг, төвийн захирал, дарга нарт үүрэг болгов.

2009.11.30-ны өдрийн 10 цагийн байдлаар томуугийн цартахлын А хүрээний (H1N1) вирүсийн халдварын лабораториор онош нь батлагдсан тохиолдол Улаанбаатар хотод 792, хөдөө орон нутагт 363, нийт 1155 байв.

#### **Боловсролын салбарт:**

**Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол.** Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 416 дугаар тушаалаар батлагдсан ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлж, дүгнэх түр аргачлалыг туршилтад хийсэн дүн шинжилгээг үндэслэн “**Багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх аргачлал**”-ыг шинэчлэн боловсруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 482 дугаар тушаалаар баталлаа. Уг аргачлалыг 2010 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөх бөгөөд боловсролын салбарын шинэчлэлийн бодлого, багшийн ажлын онцлогт нийцүүлэн багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх үйл ажиллагааг боловсронгуй болгоход энэхүү аргачлал зохих тус дэм болно гэж үзэж байна.

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт Монгол Улс 2009.11.04-нөөс шилжсэнтэй холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор ерөнхий эрдмийн хичээлүүдийг АНХ УДАА орон даяар радио, телевизүүдээр заах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүллээ. Энэ хугацаанд нийт 150 цагийн теле хичээлийг 75 багш, 42 цагийн радио хичээлийг 20 багш тус тус удирдан явуулсны зэрэгцээ теле хичээлүүдийг [www.tvnicheel.mn](http://www.tvnicheel.mn) сайтад байршуулах, хичээлүүдийг багцлан цахим хэлбэрээр сургуулиудад хүргэх, радио, телевиз, интернетээр суралцагчдын асуусан асуултад хариулт өгөх боломжийг бүрдүүлэн ажиллалаа. Ийнхүү ЕБС-ийн хичээлийг теле болон онлайн, радио хэлбэрээр заасан нь бага, дунд боловсролын салбарт ЗАЙН СУРГАЛТЫГ НЭВТРҮҮЛЭХ АНХНЫ АЛХАМ болсон бөгөөд ингэснээр багшийн заах арга зүйг шинэчлэх, харилцан бие биеэсээ суралцах боломж бүрдүүлсэн төдийгүй боловсролын салбарын үйл ажиллагааг эцэг, эх, олон нийтэд нээлттэй танилцуулахад зохих хувь нэмэр үзүүлээ.

Монгол Улсын Ерөнхий сайд боловсролын салбарын төлөөлөлтэй хийсэн уулзалтын дагуу “Боловсролын салбарын бодлогын түвшинд 2009-2012 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүллээ. Төлөвлөгөөний төсөлд цэцэрлэгийн барилгын стандартыг боловсруулж батлуулах, 1000 өрхөд ногдох цэцэрлэгийн барилгын индексийг тооцох, бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсронгуй болгох, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, сургалтын системийг нэвтрүүлэх, боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх зэрэг өнөөгийн тулгамдсан асуудлыг тусгалаа.

2005-2008 онд хэвлэгдсэн хувилбарт сурах бичгийг ЕБС-уудад нийлүүлэх тендерийн материалыг 2009.11.04-ний өдөр хүлээн авч уг тендерийн үнэлгээний хороодыг (бага, дунд, ахлах ангийн) хуралдуулан зохих шийдвэр гаргаж, үнэлгээний хяналтын шатны шийдвэрийг тендерт оролцогчдод хүргүүлээд байна. АХБ-ны санхүүжилтээр хувилбарт сурах бичгийг худалдан авахтай холбогдуулан үнэлгээний хороодын хяналтын шатны шийдвэрийг АХБ-нд явуулав.

Монгол Улсын 26 дахь Ерөнхий сайд С.Батболдын “Боловсролын салбарынхантай хийсэн уулзалт”-аас өгсөн чиг үүргийн дагуу Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ЕБС-ийг байгуулах ажилтай холбогдуулан бэлтгэл ажлыг хийж эхлээд байгаа бөгөөд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Улаанбаатар Элит Олон Улсын сургууль, Шинэ Монгол Олон Улсын сургууль, Орчлон сургууль дээр холбогдох мэргэжилтэн нарыг томилон очуулж судалгаа хийлгэж эхлээд байгаагийн зэрэгцээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ЕБС байгуулахтай холбогдуулан Кембрижийн Олон Улсын Стандартыг судалгааны үндсэн дээр сонголт хийн гүнзгийрүүлэн судалж, уг сургуулийг байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж байна.

Байгаль орчны боловсролын хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор “Эх дэлхий-3” сургалтын багц материал, гарын авлагыг дахин хэвлүүлж албан бус боловсролын “Гэгээрэл” төвүүдээр тараахад бэлэн болгоод байна. Үүнд “Ус чандмань эрдэнэ”, “Цэвэр орчин бидний амьдрал” гарын авлага, зурагт хуудас, хүүхэлдэйн кино багтаж байна. Уг багц материалын дагуу сургагч багш бэлтгэх ажлыг 12 дугаар сард хийхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байгаагийн зэрэгцээ “Эх дэлхий-4” багц материал: гай газар дороос (гарын авлага), (зурагт хуудас), (Байгалийн гамшиг болсон үед юу хийх ёстой вэ?) (зурагт хуудас), байгалийн гамшигийн төрлүүд (зурагт хуудас)-ыг боловсруулан хэвлүүлэх бэлтгэлийг хангав.

Дүйцсэн сургалтын материалын хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэхийн тулд бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын 107 модулийг CD хэлбэрт оруулан “Гэгээрэл” төвүүдэд тараахад бэлэн болгоод байна. Үүнд модуль-107, амьдрах ухааны гарын авлага-10, эрүүл мэндийн гарын авлага-1, хөтөлбөр-1, журам-1, дүйцсэн сургалтын 20 модулийг багтаасан болно. Албан бус боловсрол болон насанд хүрэгчдийн боловсролын хөтөлбөрийг дахин шинэчлэн боловсруулж хэвлэхэд бэлэн болгов.

Албан бус боловсрол болон насанд хүрэгчдийн боловсролын хэрэгцээг тандан судлах зорилгоор багш бэлтгэдэг их, дээд сургуулийн удирдлага, багш, оюутан 410 хүнээс асуулга, ярилцлага, судалгааны аргаар судалгаа авч үр дүнг SPSS программд оруулан тайланг англи, монгол дээр бэлтгэн холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

**Дээд болон мэргэжлийн боловсрол.** Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, танилцуулгыг эцэслэн боловсруулж, 2009.11.17-ны 1а/6979 тоот албан бичгээр Хууль, зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна. Хуульд оруулах өөрчлөлтийн үндсэн агуулга нь дээд боловсролын сургалтын байгууллагыг аттестатчилах журам боловсруулах эрхийг боловсролын асуудал эрхэлсэн сайдад өгөх, аттестатчилалд тэнцээгүй сургалтын байгууллагад хүлээлгэх хариуцлагыг илүү тодорхой болгоход оршиж байгаа болно.

Дээд боловсролын сургалтын байгууллагаас Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагад хандахад өгдөг үйлчилгээний хураамжийн хэмжээг өөрчлөхөөр шийдвэрлэв. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн орлогын эх үүсвэр болох төлбөрийн хэмжээг 2004 оноос хойш бодит зардалтайгаа уялдуулж нэмэгдүүлээгүй байдлыг залруулах, 2007 онд анхны болон хоёр дахь удаагийн магадлан итгэмжлэлийн урьдчилсан шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг шинэчилснээр магадлан итгэмжлэл хийлгэх сургуулийн тоо эрс цөөрсөн, цаашид шинээр магадлан итгэмжлүүлэх сургуулийн нөөц багассан болон хоёр дахь магадлан итгэмжлэлийн хүчинтэй байх хугацааг 10 жилээр тогтоосон тул 2004 онд эхэлж хоёр дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн сургуулиуд 2014 оноос Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлд хандахаар байгаа нь санхүүжилтийн байдлыг хүндрүүлсэн зэрэг нөхцөл байдлыг залруулах боломжийг олгох юм. Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журмын төслийг боловсруулаад байна.

Газарчин дээд сургууль, Аварга дээд сургууль, Хүмүүнлэгийн их сургуулиас профессор, дэд профессорын цолд нэр дэвшүүлэн ирүүлсэн багш нарын материалыг судлан Хүмүүнлэгийн их сургуулийн 5 багшид профессорын, 4 багшид дэд профессорын цол олгохоор шийдвэрлэж, Газарчин, Аварга дээд сургуулийн багш нар профессор, дэд профессорын шаардлага хангаагүй байгаа талаар зохих хариу өглөө.

А хүрээний H1N1 вирусийн буюу гахайн томууны ханиадтай тэмцэх ажлын хүрээнд ОБЕГ, МОХ, ХӨСҮТ-ийн холбогдох хүмүүтсэй хамтран их, дээд сургуулийн оюутны өвчлөлийн өнөөгийн байдалд судалгаа хийсний үндсэн дээр дотуур байранд сууж байгаа оюутнуудад төрөөс хүнсний нэмэлт бүтээгдэхүүн олгуулах зорилгоор Улаанбаатар хотод байрлалтай их, дээд сургууль, коллежийн нийт 55 дотуур байрыг дүүргээр ангилан, тэдгээрт оршин сууж байгаа 12347 оюутны судалгааг овог нэр, регистрийн дугаар, сургуулийн харъяаллаар нарийвчлан гаргаж Нийслэлийн Халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн олгуулах арга хэмжээ авлаа.

“Австралийн Викториа мужийн Магадлан итгэмжлэх байгууллагад туршлага судалсны дагуу Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын албанаас хийх ажлын төлөвлөгөө”-г сайдаар батлуулан хэрэгжүүлж байна. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлснээр “Багш” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн эрх зүйн орчин олон улсын түвшинд хүрч, бусад мэргэжлийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд жишиг загвар болох юм. Түүнчлэн энэ төлөвлөгөөний хүрээнд МУБИС-ийн Багшийн сургуулийн “Бага ангийн багш” бэлтгэх сургалтын хөтөлбөрийг Австрали Улсын Викториагийн Багшийн дээд сургууль /Victorian Institute of Teaching-аар магадлан итгэмжлүүлэх бэлтгэл ажлыг хангах болно.

Кувейтийн Засгийн газрын зээлээр санхүүжүүлэх их, дээд сургуулийн лабораториудын төслийг бэлтгэн яамны нэгжийн дарга нарын хурлаар хэлэлцүүлэн Сангийн яаманд хүргүүлсний дээр дээд боловсролыг дэмжих хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулаад байна.

Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд хэрэгцээтэй байгаа, ойрын 2 жилд хэвлэгдэх сурах бичгийн жагсаалтыг гаргаж эхний ээлжинд хэвлүүлэх зарим сурах бичгийн хэвлэлтийн зардлыг “Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр” төслөөс гаргахаар тохиролцов.

“Хөдөлмөр эрхлээгүй залуучууд, насанд хүрэгчдийн мэргэжлийн албан бус сургалт”-ын үр дүнг хэлэлцэх зөвлөлдөх уулзалтыг төслийн багтай хамтран зохион байгуулж, төслийн санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч, төслийн үр шимийг хүртэгч, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт үйл ажиллагаа явуулдаг төслийг сонирхогч бүх талын төлөөлөл болох 70 гаруй хүмүүс оролцуулав. Хөдөлмөр эрхлээгүй залуучууд, насанд хүрэгчдийн мэргэжлийн албан бус сургалтын төслийн зорилго нь барилгын салбарын эрэлт хэрэгцээнд нийцсэн богино хугацааны сургалтын хүртээмжийг сайжруулах замаар хөдөлмөр эрхлээгүй залуучууд, насанд хүрэгчдийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг өсгөхөд чиглэгдэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар мэргэжлийн ур чадвар олгох түр сургалтуудыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах загварыг туршин, хэрэгжүүлж байна. Энэ утгаараа уг төслийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, алдаа, оноог нухацтай авч хэлэлцэх нь мэргэжлийн боловсрол, сургалтын чиглэлээр цаашид хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тус болно гэж үзэж байна.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам болон Боловсрол, соёл шинжлэх ухааны яам хамтран боловсруулсан мэргэшсэн жолооч бэлтгэх тухай журмын төсөлд ХААИС, ШУТИС-ийн Механик инженерийн сургуулийн мэргэжлийн багаас санал авч нэгтгэн хүргүүлээд байна.

Барилгын коллежийн оюутны холбоо, нийт оюутнаас 2009.10.30-нд гаргасан санал, албан шаардлагын дагуу ажлын хэсгийг байгуулан 2009.11.07-13-ны өдөр тус сургууль дээр ажиллуулж, ажлын хэсгийн дүгнэлтийг тус коллежийн Удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

2010-2011 оны хичээлийн жилд шинээр мэргэжил нээх санал тавьсан дээд сургуулиудын хүсэлтийг судлан үзэж, дүгнэлт гаргах комиссыг сайдын 2009.11.02-ны 455 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж, энэ ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн ЭМШУИС-д хөдөлгөөн засалч, нүүр амны эрүүл ахуйч мэргэжлээр бакалаврын, “Ач” дээд сургуульд уламжлалт анаах ухааны мэргэжлээр бакалаврын, Улаанбаатар дээд сургуульд хөдөө аж ахуйн биотехнологи, компьютерийн техник хангамжийн бакалаврын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгов. Энэ жил 26 сургууль 96 чиглэлээр шинээр бакалаврын түвшний сургалт эрхлэх хүсэлт ирүүлснийг судлан Засгийн газрын үйл ажиллагааны 2008-2012 оны хөтөлбөрийн 1.1.14-ийг зорилтод нийцүүлэн инженер, техник технологи, хөдөө аж ахуйн мэргэжлээр тавьсан хүсэлтүүдийг зөвшөөрч, эдийн засаг, хууль, гадаад хэлний мэргэжлээр тавьсан хүсэлтүүдийг шийдвэрлэх боломжгүй талаар хариу өгөөд байна.

ШУТИС-ийн профессорын багуудын боловсруулсан Иргэний ба үйлдвэрлэлийн барилга, Архитектур, химийн технологи зэрэг 14 мэргэжлийн чиглэлээр бакалаврын боловсролын стандартыг холбогдох стандартчиллын дэд хороогоор хэлэлцүүлж, дэмжүүлээд байгаагийн зэрэгцээ докторын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулах хүсэлтүүдийг судалж, 12 зөвлөл байгуулав.

Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газрын тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулав. Бакалаврын шатны сургалтад хамрагдах 37 иргэн, магистрийн шатны сургалтад хамрагдах 12 иргэн бүртгүүлснээс англи хэл болон мэргэжлийн шалгалт (математик ба хими) авч 5 бакалавр, 6 магистрийн нэрийг дэвшүүлээд байна.

Монгол Улсын их, дээд сургуулийн 1-3 дугаар ангийн оюутны дунд нээлттэй зарласан Америкийн Нэгдсэн Улс /АНУ/-ын Засгийн газрын бүрэн тэтгэлгийн сонгон шалгаруулалтын англи хэлний ярилцлагыг явуулав. Ярилцлага авсан комиссын бүрэлдэхүүнд АНУ-ын элчин сайдын яамнаас 3 хүн, World Learning сургалтын төвийн захирал С.Өлзийжаргал нарыг оролцуулав. Ярилцлагад нийт 20 оюутан оролцсон бөгөөд эдгээрээс 4 оюутныг 1 жилийн хугацаатайгаар, 5 оюутныг 1 улирлын хугацаатайгаар АНУ-ын их, дээд сургуульд оюутан солилцооны шугамаар сургах болно. Бүх зардлыг АНУ-ын Засгийн газраас бүрэн хариуцана.

Боловсролын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, БНСУ-ын иргэн Ким Ён Квон, Жон Сүн Хүн нарын “Хүрээ” дээд сургуулийн үүсгэн байгуулагчийн эрх шилжүүлэх тухай 2009.07.20-ны өдрийн гэрээг үндэслэн БНСУ-ын Пэжэ их сургуулийн захирал Жон Сүн Квоныг “Хүрээ” дээд сургуулийн үүсгэн байгуулагчаар тэмдэглэн сайдын 2009.11.02-ны 457 дугаар тушаалаар улсын бүртгэлд өөрчлөлт орууллаа.

**Соёл, урлаг.** Соёлын өвийг хамгаалах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж байгаагийн хамт “Хүүхдэд зориулсан уран бүтээл тууривахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулан Засгийн газрын 2009.11.18-ны 344 дүгээр тогтоолоор батлууллаа. Уг тогтоолоор дээрх журамд дараах өөрчлөлт орууллаа. Тухайн жилд уран бүтээлийн ямар төрөл, сэдвээр шалгаруулалт явуулахыг тодорхойлж, уг шалгаруулалтыг жилд нэг удаа явуулах, уран бүтээлийн төсөл боловсруулах болон туурвих хугацаа, төсөл шалгаруулахад тухайн төслийн багийн гишүүдийн ажлын туршлага, өмнө туурвисан бүтээлийн чанар зэргийг харгалзахаар тусгалаа.

Төв, орон нутгийн соёл, урлагийн байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан “Засаглал ба удирдах зөвлөл”, “Сан бүрдүүлэлт”, “Соёл, урлагийн нөлөөлөл” сэдэвт сургалтыг МУЗ-тэй хамтран 2009.11.03-05-ны хооронд Улаанбаатар хотод зохион байгууллаа. Тус сургалтад төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл 60 орчим хүнийг хамрууллаа. Буриадын соёл, урлаг, спортын олон улсын “Алтаргана-2010” наадмыг зохион байгуулах асуудлыг боловсруулж, яамдын санал авч нэгтгээд байна. “Алтан намар 2009” наадамд хөрөнгө гаргах асуудлыг сайдын 2009 оны 451 дүгээр тушаалаар шийдвэрлэж, цуврал арга хэмжээг зохион байгуулж байгаа бөгөөд хаалтын тоглолтыг 12 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэж байна.

АНУ-ын Элчин сайдын яамнаас хэрэгжүүлж буй “Амарбаясгалант хийдийг хамгаалах” төслийн шугамаар ирсэн АНУ-ын галын дохиолол хамгаалалтын 2 шинжээчийг Амарбаясгалант хийдийн барилгатай танилцуулж, лам нарт сургалт зохион байгуулсны гадна “Түүхэн барилгыг галын аюулаас хамгаалах” сэдэвт сургалтыг Дүрслэх урлагийн музей дээр явуулав. Энэхүү сургалтад монголын түүхэн барилгуудад үйл ажиллагаа явуулдаг музейдүүдээс гадна шашны байгууллага, сүм хийдээс оролцлоо.

Засгийн газрын 2009.11.18-ны тогтоолоор олон улсын уралдаан наадамд амжилттай оролцсон 16 уран бүтээлчид нийт 132.5 сая төгрөгийн мөнгөн шагнал олгосон нь энэ онд олон улсын уралдаан наадамд оролцож, амжилт үзүүлсэн уран бүтээлчдийн тоо, чанарт онцгой ахиц гарсан нь харагдаж байна. “Хөгжмийн томоохон хэлбэрийн бүтээлийг улсын санд худалдаж авах тухай” Засгийн газрын 115 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах зөвлөлийг сайдын тушаалаар байгуулж ажилд нь оруулав.

**Шинжлэх ухаан, технологи.** Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс боловсруулсан Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн төсөлд шинжээчдийн багаар дүгнэлт гаргуулан Зохицуулах зөвлөлд хүлээн авсны зэрэгцээ “**Эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, санхүүжүүлэх журам**”-ын төслийг бэлтгэн эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиудын эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн санал авч уг журмын төслийг эцэслэн боловсруулж яамдаас санал авахаар бэлтгэлийг хангав. Мөн инновацийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хамт Нэгжийн дарга нарын хуралд оруулан хэлэлцүүлж, яамдаас санал авахаар бэлтгэж байна. Европын Холбоо, Латви Улстай шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт хамтран ажиллах саналыг боловсруулан ГХЯ-д хүргүүлэв.

Улсын захиалгаар 2010 оноос эхлэн хэрэгжүүлэхээр зарласан шинжлэх ухаан, технологийн 22 төслийн чиглэлээр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад шинжлэх ухааны 21 чиглэлд хамаарах 46 төслийн саналыг хүлээн авч “**Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх журам**”-ын дагуу БСШУ-ы сайдын тушаалаар шинжээчдийн ажлын хэсэг байгуулан төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргуулав. Сонгон шалгаруулалтын 14 үзүүлэлтээр гаргасан шинжээчдийн үнэлгээний дүнг нэгтгэн чиглэл тус бүрээр онооны дарааллаар байр эзлүүлэн дүнг нэгтгэн гаргав. Мөн БСШУ-ны сайдын тушаалаар батлагдсан ажлын хэсэг 2010 оноос хэрэгжүүлэх суурь судалгааны сэдэвт ажлыг эцэслэн сонгох ажлыг зохион байгуулж 2010 оноос 27 сэдэвт ажлыг хэрэгжүүлэхээр шалгаруулаад байна.

Гадаад, дотоодын дэвшилтэт технологийг туршин нэвтрүүлэх, нутагшуулах зорилгоор инновацийн зарим төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. БСШУ-ы сайдын тушаалаар байгуулагдсан инновацийн төслийг сонгон шалгаруулах ажлын хэсгээр дэмжигдсэн “*Ойн үйлдвэрлэлийн хоёрдогч нөөцийг гүн боловсруулж, зоргоодсон хавтан үйлдвэрлэх технологи*”, “*Сум, сууринд баригдах цэцэрлэг, яслийн барилгын туршилт, дүгнэлт*”, “*Тэжээл үйлдвэрлэлийн цогц технологи*”, “*Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр*”, “*Зарим бүс нутагт малын чанарыг сайжруулах оновчтой менежмент*”, “*Талбай услах төхөөрөмж*” зэрэг 6 төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулсны үндсэн дээр судалгаа, туршилтын ажлуудыг эхлүүлээд байна.

2008 онд дууссан шинжлэх ухаан, технологийн төслийн судалгааг гаргаж захиалагчдад хүргүүлсний дагуу үр дүнг хүлээн авсан тухай яамдын тайланг авч нэгтгэж байна. Мөн ХХААХҮЯ, ЭМЯ-ны захиалгаар гүйцэтгэж 2008 онд дууссан төслийн үр дүнг хүлээн авах болон тайланг хэлэлцэх үйл ажиллагаанд яамны төлөөллийг оролцуулан ШУТ-ийн төслийн үр дүнг хүлээн авч байгаа байдалтай газар дээр нь танилцлаа.

ШУ-ны ажилтны өдрийг угтан зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан БСШУ-ны сайдын 2009.11.02-ны өдрийн 460 дугаар тушаалаар баталгаажуулан, эрдэм шинжилгээний байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулав. Энэ ажлын хүрээнд шинжлэх ухааны 2009 оны шилдэг бүтээлийн уралдаанд дэвшүүлсэн 14 бүтээлийг хүлээн авч шалгаруулах ажлыг зохион байгууллаа. Эдгээр бүтээлээс МУИС-ийн ЭЗС-ийн багш, шинжлэх ухааны доктор Р.Энхбатын “Квазигүдгэр программчлал” бүтээл, Анагаах ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Хавдар судлалын үндэсний төвийн зөвлөх, шинжлэх ухааны доктор асан Д.Самбуупүрэв, Эмгэг судлалын төвийн эмч Ч.Энхтуул, Хавдар судлалын үндэсний төвийн эмэгтэйчүүдийн зөвлөх Д.Авирмэд нарын “Умайн салстын эмгэг өөрчлөлт, хорт хавдар, урьтал өвчний эд судлалын оношзүй” бүтээл, ШУТИС-ийн багш, шинжлэх доктор Д.Дашжамц, доктор Ж.Зулзагабаатар, Г.Намхайжанцан, З.Биндэръяа нарын “Монгол орны геотехникийн нөхцөл” бүтээл, ШУА-ийн Түүхийн хүрээлэншийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Батсүрэнгийн “Өндөр тэрэгтнүүд ба эртний түрэгүүд /VI-IX зуун/” бүтээлүүд өндөр үнэлгээ авлаа.



**Салбарын санхүү, хөрөнгө оруулалт.** Монгол Улсын Их Хурлаар БСШУ-ы салбарын 2010 оны төсөв 2009 оны төсөвтэй харьцуулахад 42,1 тэрбум төгрөгөөр илүү буюу 486.3 тэрбум төгрөгөөр батлагдлаа. Үүнээс урсгал зардалд 430.3 тэрбум төгрөг, 56.1 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын зардалд төсөвлөгдсөн байна. Нийт зардалын 88.5 хувийг урсгал зардал, 11.5 хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байгаа ба ДНБ-ий 6.8 хувь, улсын төсвийн нийт орлогын 33.6 хувийг БСШУ-ы салбар эзэлж байна. Харин боловсролын салбар нь улсын төсвийн нийт орлогын 30.2 хувийг эзэлж байна.

Арабын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн саналыг боловсрууллаа. Уг төслийн саналд 2010 оны төсөв болон бусад арга хэмжээнд санхүүжилтийн эх үүсвэр нь тусгагдаагүй хөрөнгө оруулалтын хэрэгцээг нэгтгэн тусгасан болно. Хүүхдийн цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулийн барилга, тоног төхөөрөмжийн шинэчлэлд 50.5 сая доллар, их, дээд сургуулийн тоног төхөөрөмжийн шинэчлэлд 7.1 сая, нийт 57.6 сая долларын төслийг бэлтгэв. Мөн цэцэрлэгийн 105994 хүүхдэд олгох 0.5 кг аарц, 0.5 кг чацарганы 609.4 сая төгрөгийн тооцоо, хуваарийг боловсруулав.

**Салбарын гадаад харилцаа.** “Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын боловсролын үнэмлэх, эрдмийн зэргийн гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол”-ын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв. Уг протоколд гарын үсэг зурах эрхийг Ерөнхий сайдын захирамжаар БСШУ-ны сайдад олголоо. Энэхүү протоколоор 1998.12.11-ний өдөр Бээжин хотноо байгуулсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Боловсролын үнэмлэх, эрдмийн зэргийн гэрчилгээг харилцах хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр”-ийн хэрэгжих хугацааг үргэлжлүүлэн сэргээж, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа юм.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 1994.04.29-ний өдөр байгуулсан соёлын салбарт хамтран ажиллах тухай Хэлэлцээрийг үндэслэн, хоёр улсын нөхөрсөг харилцааг бэхжүүлэх, соёлын солилцоо, хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор хоёр улсын Засгийн газар хооронд 2009-2012 онд хэрэгжүүлэх соёлын солилцооны төлөвлөгөөний төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв. Энэхүү төлөвлөгөөнд гарын үсэг зурах эрхийг Ерөнхий сайдын захирамжаар БСШУ-ны сайдад олголоо. Энэхүү төлөвлөгөөг байгуулснаар Талууд номын сан, музей, театр, цирк, балет, кино зэрэг соёл, урлагийн байгууллага хоорондын солилцоо, хамтын ажиллагааг харилцан дэмжих, соёл, урлагийн салбарын мэргэжилтэн, уран бүтээлчдийг харилцан солилцох, соёлын үнэт зүйлсийг хадгалах, сэргээн засварлах чиглэлээр Хятадын талтай хамтран ажиллах өргөн боломж бүрдэж байна.

Монгол-Японы хооронд Соёлын харилцаа тогтоосны 36 жилийн ойг тохиолдуулан Соёлын чуулганыг 2010 оны 2 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулахаар шийдвэрлэв. Энэхүү Соёлын чуулган нь 2 жил тутам зохион байгуулагддаг соёл, урлагийн томоохон арга хэмжээний нэг бөгөөд хоёр орны соёл, урлагийн байгууллагууд хооронд туршлага судлах, сонгосон сэдвийн хүрээнд эрдэм шинжилгээний хурал болон холбогдох бусад салбар хуралдаануудыг зохион байгуулдагараа онцлог юм. 2007 оны Соёлын форум-III нь “Биет ба биет бус соёлын өвийг хадгалж хамгаалах” сэдвийн дор хуралдсан бөгөөд IV форумыг өмнөх хөтөлбөр болон зохион байгуулсан арга хэмжээний агуулгад тулгуурлан “Соёлын өвийн менежментийн уламжлал ба шинэчлэл” бүлэг сэдвийг сонгож музейн менежментийн асуудлыг онцгойлон оруулахаар тохиролцлоо.

БСШУ-ны сайд Ё.Отгонбаяр, ОХУ-ын Соёлын сайд А.А.Авдеевтэй хийсэн уулзалтын үеэр хоёр орны соёлын салбарын цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх тохиролцооны хүрээнд ОХУ-ын Соёлын яамнаас 2010 онд Пермийн бүжгийн колледжид 12 хүний бүрэлдэхүүнтэй /6 балетийн хос/, Санкт-Петербургийн театрын урлагийн академи 10 хүний бүрэлдэхүүнтэй монголын оюутнуудыг хүүхэлдэйн театрын жүжигчин мэргэжлээр авах боломж бүрдсэн мэдээллийг хүлээн авлаа. Түүнчлэн монголын музейн мэргэжилтнүүдийг 2010 онд хүлээн авч Эрмитажид хадгалагдаж буй монголын соёл, урлагийн үзмэр, цуглуулгатай танилцуулах, театр, сэргээн засварлалтын чиглэлээр богино хугацааны сургалтад хамруулах боломж бүрдлээ.

АХБ-ны Нийгмийн салбарын зээлийн хөтөлбөрийн АХБ-ны зохицуулагчид болон ЖАЙКА-гийн төлөөлөгчдийг БСШУЯ-ны холбогдох ажлын хэсэг хүлээн авч уулзалт зохион байгуулав. Уулзалтын үеэр АХБ-ны 60 сая ам.долларын, Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын 30 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр төсвийг тэнцвэржүүлэх, алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, АХБ болон Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай байгуулсан “Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөрийн

санхүүжилтийн хэлэлцээр”-ийн хэрэгжилтийн хүрээнд боловсролын салбарт авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар санал солилцов.

#### **Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн чиглэлээр:**

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн хооронд хамтран ажиллах хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээний хурлын шийдвэрийг үндэслэн НҮБ-ын Хүүхдийн сангийн “Хүүхэд хамгаалал” хөтөлбөрийн тэргүүлэх байгууллагаар НХХЯ-ыг томилсонтой холбогдуулан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, зохицуулах, дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон удирдамжийг НХХ-ийн Сайдын тушаалаар батлууллаа. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн хооронд 2007-2011 онд хамтран ажиллах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Хүүхэд хамгаалал” хөтөлбөр нь “Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх замаар хүүхдийг хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс хамгаалах төсөл” /НХХЯ/ болон “Хууль зүйн шинэтгэл” /ХЗДХЯ/ гэсэн 2 бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд ажлын хэсэг нь хөтөлбөрийн хүрээний 2 төслийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлэх, төслийн хүрээнд хийгдэх үйл ажиллагааны талаар санал зөвлөмж гаргах, төслүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх зорилготой байна.

**Гэр бүлийн тухай хуулийг** шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд хүүхдийг гадаад, дотоодын иргэдэд үрчлүүлэхтэй холбоотой хэсэгт оруулах өөрчлөлтийн талаарх санал боловсруулан яамны холбогдох дарга нар, мэргэжилтнүүдэд танилцуулан гарсан санал, зөвлөмжийн дагуу бусад улсын хууль тогтоомжид уг асуудлыг хэрхэн тусгасан талаар судалгааг хийж байна.

Дэлхийн хүн амын илтгэлийг сурталчлах ажлыг НҮБ-ын ХАС-тай хамтран зохион байгууллаа. НҮБ-ын Хүн амын сангаас жил бүр хэвлүүлдэг Дэлхийн хүн амын энэхүү илтгэл нь “Хувьсан өөрчлөгдөж буй дэлхий ертөнц: эмэгтэйчүүд, хүн ам ба уур амьсгал” гэсэн сэдвээр хэвлэгдсэн бөгөөд хэвлэлийн бага хурал зохион байгуулах, өдөр тутмын сонинд зориулсан нийтлэл бэлтгэн хэвлүүлэх зэрэг ажлыг зохион байгууллаа.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн болон Эрүүл мэндийн сайдын 2009 оны 114/269 дүгээр хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс боловсруулсан Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг сайдын зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцүүлж хуулийн үзэл баримтлал ба төслийг сайжруулан боловсруулж 2010 онд Засгийн газарт өргөн барихаар бэлтгээд байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмийн нэр төрлийг нэмэх, даатгуулагчид ойр болгох, эмийн сангуудын даатгалын байгуулагатай харьцах харьцааг хөнгөвчлөх зорилгоор шинэчлэн боловсруулсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын төслийг 10-р сарын 12-ноос 11-р сарын 12-ны хооронд Улаанбаатар хотын 4, орон нутгийн 2 эмийн санд туршиж. Энэ хугацаанд 6 эмийн сан 7523 даатгуулагчид 12,7 сая төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс даатгуулагчийн тоо 5,3 дахин, эмийн зардлын дүн 3,7 дахин нэмэгджээ. Туршилтын явцад гарсан анхаарах асуудлуудыг журмын төсөлд тусган төслийг Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлөөр батлуулахаар тогтов.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж тэтгэмжийн шинэ төрөл болох “өвчтөн сахисны тэтгэмж” бий болсон, оршуулгын тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин /ҮОМШӨ/-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг уг сангаас тэтгэврийн даатгалын санд төлж байхаар шийдвэрлэсэн, түүнчлэн Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт орж ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан нийгмийн даатгалын сангуудын зарлага энэ онд төлөвлөж байснаас зайлшгүй нэмэгдэхээр байгаа юм. Иймд даатгалын сангуудын зарлагын төсвийг тодотгохоор Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хамт боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн бариад байна.

**Хөдөлмөрийн бодлогын хүрээнд** “БНХАУ-ын мэргэжилтэй ажилчдыг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх тухай” Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүллээ. НХХЯ, БНХАУ-ын Худалдааны яамнаас байгуулсан ажлын хэсэг 2 удаа хэлэлцээ хийж, хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцсон болно. Энэхүү хэлэлцээрийг байгуулснаар зуучилж байгаа болон хүлээн авч байгаа компани, хятадын

ажилчны эрх үүрэг, хариуцлага тодорхой болж, тэдний үйл ажиллагаанд БНХАУ-ын төрийн холбогдох байгууллагын зүгээс хяналт тавих боломж бүрдэж байгаа нь нэг талаас ажилчин хүний эрхийг хангахад чиглэсэн олон улсын хэм хэмжээ хангагдах, аль аль талын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гадаадын иргэдтэй холбоотойгоор үүсдэг зохисгүй үйлдэл, эмх замбараагүй байдал багасна гэж үзэж байна. Мөн дотооддоо дутагдалтай байгаа мэргэжилтэй ажилчдыг БНХАУ-аас авснаар өөрийн орны ажил олгогчийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, гадаадын мэргэжилтэй ажилчныг дагалдуулан өөрийн иргэдийг сургах, улмаар ажилчдынхаа ур чадварыг дээшлүүлж, эдийн засгийн өсөлтийг түргэтгэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.3-т *“Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого баримтална”*, НХХЯ-ны 2009 оны үйл ажиллагааны /бүтээгдэхүүн нийлүүлэлтийн/ төлөвлөгөөны 1.2.3-т *“Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх асуудлыг цалин хөлс, хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулах чиглэлээр төрийн бус байгууллагууд, нийгмийн түншлэгч талуудтай хамтран судалгаа хийж, чиг хандлагыг тодорхойлно”* гэж тус тус заасантай холбогдуулан яамны Төрийн нарийн бичгийн даргын 2009 оны 184 дүгээр тушаалаар Цалингийн бүтцийн судалгааг явуулах ажлын хэсэг байгуулж, судалгааг зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээ авч ажиллаж байна.

Үндэсний статистикийн газраас (хуучин нэрээр) 2000 оны 4 дүгээр улирлаас эхлэн “Цалингийн түүвэр судалгаа”-г жилд нэг удаа, 2007 оноос улирал бүр ажиллагчдын хүйс, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн болон хариуцлагын хэлбэр, аймаг, нийслэлийн түвшингөөр нь гаргаж байгаа боловч уг судалгаа цалин хөлсний талаар бодлого боловсруулахад хангалттай нарийн мэдээлэл өгч чадахгүй, ялангуяа цалин хөлсний бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох боломжгүй байна. Иймд олон улсын туршлага, ялангуяа Солонгосын Хөдөлмөрийн институтын аргачлал, ОУХБ-ын зөвлөмжид тулгуурлан өмнө туршсан асуулга, зааврыг хянан боловсруулж 2010 онд уг судалгааг хийхээр төлөвлөөд байна. Ингэхдээ цалин хөлсний бүтцийн судалгааны асуулгын төслийг НХХЯ болон ОУХБ хамтран зохион байгуулсан “Цалингийн судалгааны талаарх зөвлөлдөх уулзалт”-д оролцсон хүмүүст танилцуулж санал зөвлөмжийг нь авч тусгасан. Энэхүү асуулга нь аж ахуй нэгж, байгууллагын ба хувь хүний мэдээлэл гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд энэхүү судалгаанд 1019 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдах юм. Цалингийн бүтцийн туршилтын судалгааны асуулга, маягт, бөглөх заавар, танилцуулгыг ҮСХ-той хамтран боловсруулж ҮСХ-нд батлуулахаар хүргүүлэв.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг НХХЯ, ХЗДХ-ийн сайд 2009.10.10-ны өдөр баталсны дагуу хуулийн төсөлд яамд, МАОЭНХ, МҮЭХ-ноос санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг салбарын онцлогийг харгалзан тогтоон мөрдөх, жижиг аж ахуй, худалдаа эрхлэгчид болон бүтээмж, орлого багатай, улирлын чанартай үйлдвэрлэл эрхэлдэг хөдөө аж ахуйн ажил олгогчдын үйл ажиллагааг зохицуулах, ажил олгогчдод учирч байгаа эдийн засгийн дарамтыг бууруулах зэрэг асуудлыг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаж байна.

Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар Төрийн албаны тухай хуулийн 28.4.4, 28.4.5-д заасны дагуу хувийн хэвшилд ажиллагчдын адилтгах албан тушаалын дундаж цалингийн судалгааг УИХ-аас баталсан журмын дагуу жил бүр гаргах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсэг Австралийн Пи Ди Пи компаниас судалгааны асуулга, аргачлалын талаар явуулсан сургалтад хамрагдав.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2009-2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 17 дахь хэсэгт заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг НХХ-ийн сайдын 2009 оны 154 тоот тушаалаар баталлаа.

ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын үйл ажиллагааг системчлэн сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор “Хөдөлмөрийн хяналтын үйл ажиллагаанд баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай” Монгол Улсын Шадар сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалын төсөл боловсруулж, санал авч байна.

**Нийгмийн түншлэлийн хүрээнд** Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн түншлэлийг өргөжүүлэх талаар заасан зорилтыг

хэрэгжүүлэх зорилгоор хот хөдөөгийн болон хүн амын бүлгүүдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “**Зохистой хөдөлмөрийн төлөөх үндэсний стратеги**”-ийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулахаар холбогдох яамд, газар, нийгмийн түншүүдтэй хамтран ажиллаж байна.

**Хүн амын хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд** НҮБ-ын хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр яам, холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын баг гарган хүүхдийн асрамж, халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад “**Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага Монгол Улсын стандарт**”-ын хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллаж байгаад хяналт-үнэлгээ хийв. Хяналт-үнэлгээнд Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг нийт 43 асрамж, халамж, хамгааллын байгууллага хамрагдсан бөгөөд нэгдсэн тайланг 12 сард эцэслэн гаргана.

Чадавхи бэхжүүлэх төслийн 2009 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлээ. “Хүүхэд хамгаалал” хөтөлбөр 3 дэд төсөлтэй бөгөөд төслүүдийн хоорондын уялдаа холбоо, зохицуулалтыг хангах чиг үүргийг ХЗДХЯ хэрэгжүүлж байсныг 2010 оноос НХХЯ хэрэгжүүлэхээр боллоо. Тус яаманд хэрэгждэг “Чадавхи бэхжүүлэх” төсөл, Хүүхдийн төлөө газарт хэрэгждэг “Хүүхэд хамгааллын асуудлаарх ухуулга сурталчилгаа” төслийг нэгтгэн “Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх замаар хүүхдийг хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс хамгаалах” төсөл болгон өргөжүүлэн 2010 оноос НХХЯ хариуцан хэрэгжүүлэхээр боллоо. “Хүүхэд хамгаалал” хөтөлбөр болон тус яам хариуцан хэрэгжүүлэх дэд төслийн ажлын хэсгийг байгуулаад байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7.2.2-д Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь “Хамгаалах байранд тавигдах наад захын шаардлагыг тодорхойлох” чиг үүргийг тусгасан. Хуулийн хэрэгжилтийг хангах, нийгэмд бий болсон хэрэгцээ шаардлагыг үндэслэн гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн, хүн худалдах гэмт хэргийн хохирогч нарт үйлчилгээ үзүүлэх, тэдний аюулгүй байдлыг хангах зорилгоор “Хохирогчийг хамгаалах байр, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” Монгол Улсын стандартын төслийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо, дэмжлэгтэйгээр боловсрууллаа. Энэхүү стандартын төслийг боловсруулахад НХХЯ, Стандартчилал хэмжил зүйн газар, ХХҮГ Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүйсийн тэгш эрхийн төв, ЭКПАТ-ын Монгол дахь сүлжээ, Хүүхэд, эмэгтэйчүүдийн халамж, хамгаалал, Монголын Хүүхдийн эрхийн үндэсний төв Төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 12 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан бөгөөд стандартын төслийг 2 удаагийн хурлаар хэлэлцүүлж, саналыг тусган Нийгмийн даатгал, хөдөлмөр халамжийн үйлчилгээний стандартчиллын дэд хорооны 2009.11.02-ны хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн болно. Стандартын төслийг батлуулахаар СХЗҮТ-д албан бичгээр хүргүүлээд байна.

Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2005 оны 15 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн ур чадварын шалгалт зохион байгуулах, мэргэжлийн гэрчилгээ олгох журам”-ыг үндэслэн 2009.09.15-аас эхлэн үйлдвэр дээрх сургалтыг зохион байгуулж нийт 3500 иргэн хамрагдсаны I шатны ур чадварын шалгалтанд нийт 870 иргэн хамрагдаж 656 нь тэнцсэн байна. Мэргэжлийн шалгах эрхтэй багш нар онол, дадлага гэсэн 2 хэлбэрээр шалгалтыг зохион байгуулж авах ажил үргэлжилж байна.

Мянганы сорилын сантай хамтран үйлдвэр, аж ахуйн газруудын хүний нөөцийн менежерүүдэд “Хөдөлмөр эрхлэлт, хүний нөөцийн хөгжил”-ийн асуудлаар 2 өдрийн цуврал сургалтыг 4 удаа зохион байгуулэв. Сургалтаар мэргэжлийн зэрэг дэвийн үндэсний тогтолцоо, түүнийг бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоо, чадамжид суурилсан сургалт, эрэлтэд нийцсэн техник мэргэжлийн боловсрол сургалт, ажил мэргэжлийн дүн шинжилгээ хийх арга, ажлын байрны тодорхойлолт зэргийн талаар ажил олгогчдод мэдээлэл өгч байна.

НХХЯ-наас аймаг, дүүргийн ХХҮХ-т бүртгэлтэй, 70 ба түүнээс дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан, ажилгүй иргэдийн 150 төслөөс 128 төслийг сонгон шалгаруулж, 425.712.0 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас гаргахаар шийдвэрлэв. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан 1071.1 мянган төгрөгийн дундаж өртөгтэй, 441 ажлын байрыг шинээр бий болно.

Хараагүй иргэдийн зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Хараагүйчүүдийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн цахилгааны эд анги угсрах шугам, мужааны цехийн өргөтгөл, ажиллагчдын цайны газрын тоног төхөөрөмжийг шинэчлэхэд 100.0 сая, Монголын хараагүйчүүдийн Үндэсний холбооны Бэст радиогийн 65.0 сая төгрөгийн төслүүдийг тус тус санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн болно.

**Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн асуудлаар:** Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2010-2011 улсын хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангаж, хэлэлцээрийг Засгийн газар, МҮЭ-ийн холбоо, МАОЭНХолбооноос томилогдсон төлөөлөгчид Хөдөлмөрийн хуулийн хоёрдугаар бүлгийн 19, 20 дахь хэсэгт заасны дагуу 2009.11.19-нд байгуулж, гурван тал гарын үсэг зурав. Засгийн газраас баримтлах чиглэлийн дагуу хэлэлцээрийг явуулж, улсын хэлэлцээрт 30 гаруй асуудлыг талууд харилцан зөвшилцөж тусгав. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2010-2011 улсын хэлэлцээрт тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргав.

**“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр”**-ийг хэрэгжүүлэх хоёрдахь шатны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгөх, дэмжин туслах үйлчилгээг бий болгох, сургалт сурталчилгааны материал бэлтгэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс сэргийлье” эрүүл мэнд зайны сургалтын интерактив мастер CD/цахим ном хийхээр Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвтэй хамтран ажил гүйцэтгэх гэрээ байгуулав.

**Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:** Хүнс хоол тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөрийн хүрээнд хүнсний талон олгох асуудлаар 2 өдрийн сургалтыг зохион байгуулж аймаг, нийслэлийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга, хүн амын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамрууллаа. Мөн **“Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөр”** төслийн хүрээнд хүнсний талоныг 2009 оны 11 сараас иргэдэд олгож эхэллээ.

Монгол Улсад томуугийн А хүрээний (H1N1) вирусийн халдвар тархаж байгаатай холбогдуулан томуугаас урьдчилан сэргийлэх зорилгоор вирусийн халдварт өртөх эрсдэл бүхий зарим иргэдийн биеийн эсэргүүцлийг сайжруулж, урьдчилан сэргийлэхэд амин дэм бүхий хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болох аарц, чацаргана, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хангах нэг удаагийн арга хэмжээг сард 7 хоногийн хугацаатайгаар 2 үе шатаар хэрэгжүүлнэ.

**Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт:** Тайландын Бангкок хотноо зохион байгуулагдсан тэтгэврийн сангийн дугуй ширээний уулзалтад Азийн болон өмнөд Америкийн 20 гаруй орноос нийт 130 гаруй олон улсын хөрөнгө оруулалтын байгууллагуудын болон тэтгэврийн сангийн төлөөлөгчид оролцлоо. Зөвлөлдөх уулзалтын үеэр Дэлхийн Санхүүгийн хямралын дараах Азийн санхүүгийн чиг хандлага, Эрсдлийн удирдлага болон тэтгэврийн сангуудын туршлага, Азийн хөрөнгийн зах зээл дээрх хөрөнгө оруулалтын стратегиуд, ирээдүйд хийх хөрөнгө оруулалтын хэлбэрүүд, хөрөнгө оруулалтын дэд бүтцийг сонгох зэрэг өргөн хүрээний асуудлаар харилцан ярилцаж, санал солилцсон нь ач холбогдолтой болов.

**“Эмнэлгийн хуудас олгох журам”**-ийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны “Журам батлах тухай” 124 дугаар тушааллаар батлуулсан. Хууль зүйн яамнаас журмыг хянаж үзээд зарим заалтыг хянуулахаар дүгнэлт ирүүлсэн билээ. Уг дүгнэлтийн дагуу журамд өөрчлөлт оруулахаар дахин боловсруулж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалын төслийг боловсруулаад байна.

Малчдыг Нийгмийн даатгалд хамруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай түр журмын төслийг танилцуулгын хамт боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газраас санал авахаар хүргүүлээд байна.

**Хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд:** 2009.11.17-18-ны өдрүүдэд болсон Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын ээлжит VIII хуралдаанд оролцов.

ХБНГУ-ын Фридрих Эбертийн сангийн шугамаар Германы Баден-Вюртемберг мужийн тэтгэврийн даатгалын байгууллагын мэргэжилтнүүд Улаанбаатарт ажиллаж Монголын тэтгэврийн даатгалын асуудлаар НХХЯ, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, УИХ-ын даргын зөвлөх, Сангийн яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, МҮЭХ, МАОЭНХ зэрэг газрын удирдлага, ажилтнуудтай уулзалт хийж, тэтгэврийн тогтолцооны өнөөгийн байдал, шинэчлэлийн асуудлаар урьдчилсан санал, дүгнэлтээ танилцуулав.

НХХ-ийн сайд Т.Ганди ХБНГУ-ын Фридрих Эбертийн сангийн Бээжин дэх суурин төлөөлөгч Ноён Свен Шверженскийг хүлээн авч уулзан тэтгэврийн даатгалын шинэчлэлийн хүрээнд хоёр талын хамтын ажиллагааны талаар санал солилцсон ба 2010 онд Монгол Улсын Засгийн газар, УИХ-ын төлөөлөл бүхий багийг ХБНГУ-ын тэтгэврийн даатгалын тогтолцоо, туршлагатай танилцуулах ажлыг дэмжиж зохион байгуулах, НХХЯ-наас тэтгэврийн даатгалын асуудлаар ажилладаг гадаад хэлтэй нэг хүнийг Германы тэтгэврийн газарт урьж 3 сар дадлагажуулахаар тохиролцлоо.

ХБНГУ-ын Холбооны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллах хүрээнд Германы протез, ортопедийн тоног төхөөрөмж үйлдвэрлэлийн Отто Бок компаниас мэргэжилтэн урьж Сэргээн засалтын Үндэсний төвд суурилуулсан тоног төхөөрөмж дээр ажиллах монгол мэргэжилтнүүдийг сургах хэрэгцээ, цаашид Монголд энэ чиглэлийн үйлчилгээг өргөжүүлэх, СЗҮТ-ийг бэхжүүлэх, сургалт зохион байгуулах арга, хэлбэрийг тодорхойлох зорилгоор ажиллуулав. НХХ-ийн дэд сайд Д.Нямхүү уг төлөөлөгчийг хүлээн авч уулзан хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Нью-Йоркт төвтэй Монгол-Америкийн соёлын нийгэмлэгт хүнд нөхцөлд байгаа хүүхдийг хамгаалах, нийгэмшүүлэх төсөл хэрэгжүүлэхэд хамтран ажиллах асуудлаар санал хүргүүлж, тус нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр тохиролцов.

**Олон талт хамтын ажиллагааны хүрээнд:** Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди ОУВС-ийн эксперт ноён Стефз Барнер тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. НХХ-ийн сайд нийгмийн халамжийн шинэчлэлийн хүрээнд хууль эрх зүйн орчныг шинэчлэх ажлын явц, тулгамдаж буй асуудлууд, цаашдын төлөвлөгөөний талаар танилцуулж, санал солилцов.

Ази, Номхон Далайн орнуудын Хөдөлмөрийн Аюулгүй Ажиллагаа, Эрүүл Ахуйн Байгууллага (АНДХААЭАБ)-тай хамтран ажиллах боломжийг судалж, холбогдох танилцуулгыг бэлтгэн Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвд хүргүүлээ.

Олон Улсын Нийгмийн хамгааллын нийгэмлэгтэй цаашид хамтын ажиллагаагаа хэрхэн өргөжүүлэх боломж байгаа талаар судлан танилцуулга бэлтгэв.

Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөрийн Бодлогын арга хэмжээний хэрэгжилтийн II дахь шатны үнэлгээний ажлаар Монголд ажиллаж буй АХБ-ны мэргэжилтэн Клауди Бодарт тэргүүтэй АХБ/ЖАЙКА-ийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Уулзалтын үед Н.Аюуш төлөөлөгчдөд нийгмийн халамжийн шинэчлэлийн хуулиудыг боловсруулж, батлуулах явц, эмийн үнийн хөнгөлөлт, Эрүүл мэндийн даатгалын хууль, тогтолцоо, ялангуяа ЭМД-ын шимтгэлийг төрөөс санхүүжүүлэх ажлын явцын талаар дэлгэрэрэнгүй мэдээлэл өгч, цаашид үргэлжлүүлэн техникийн туслалцаа авах ажлыг харилцан авч үзэхээр тохиролцов.

НХХ-ийн сайд Т.Гандигийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 64 дүгээр чуулганы “Хүн ам ба хөгжлийн олон улсын бага хурлын 15 жилийн ойд зориулсан тусгай хуралдаан”-д оролцсон тухай танилцуулга болон бусад баримт бичгийг боловсруулж, дүнг Засгийн газрын 2009.11.18-ны өдрийн хуралдаанд танилцуулав.

НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон Улсын Пактын Нэмэлт Протоколд гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийн төслийг боловсруулан холбогдох материалуудын хамт ЗГХЭГ-т хүргүүлж, Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгч О.Энхцэцэгт НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон Улсын Пактын Нэмэлт Протоколд гарын үсэг зурах эрх олгосон 109 тоот захирамжийг гаргуулав.

ОУХБ-ын Дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлуулах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар оруулахаар хуулийн төсөл, түүний үзэл баримтлал болон бусад холбогдох материалуудыг боловсруулан яамдаас санал авахаар хүргүүлээд байна. Үүнтэй холбогдуулан ОУХБ-ын дүрэм, түүнд оруулсан 1997 оны нэмэлт, өөрчлөлтийн орчуулгыг ГХЯ-аар хянуулж баталгаажуулав.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 3 ба 4 дэх тайлан, Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцэд оруулах нэмэлт протокол болон Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протоколын дагуу өгсөн тайлангуудын мөрөөр ирүүлсэн асуулгын хариуг боловсруулж хүргүүлэв.

## **Санхүү, төсвийн талаар:**

Жагсаалт батлах тухай Засгийн газрын (2009.11.04) хуралдаанаар хэлэлцэж, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай 2009.10.30-ны өдрийн хуулиудыг үндэслэн Засгийн газрын 2009 оны 335 дугаар тогтоол гаргалаа. Энэ тогтоолоор гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх томуугийн А (H1N1) вирусийн халдварын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зориулалт бүхий эм (5 нэр төрөл), эмнэлгийн хэрэгсэл (13 нэр төрөл), оношлуур (5 нэр төрөл), тоног төхөөрөмж (12 нэр төрөл), ариутгалын бодис (4 нэр төрөл)-ын жагсаалтыг баталсан байна.

Хөрөнгө оруулалтын гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлүүдийн тухай Засгийн газрын (2009.11.11) хуралдаанаар хэлэлцэж, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Ерөнхий сайдын 2009.07.21 өдрийн 73 дугаар захирамжаар байгуулсан Оюутолгойн ордыг ашиглах хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийх ажлын хэсгийг үргэлжлүүлэн ажиллуулж, энэ ажлын хэсэгт Монгол Улсын Засгийн газар болон “Айвенхоу майнз монголиа Инк” ХХК, Айвенхоу майнз лимитед, Рио Тинто интернэшнл холдингс лимитед компани хоорондын хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурагдсанаас хойш зургаан сарын хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээний 15.7.7-д заасан Байнгын ажлын хорооны үүргийг хариуцуулан ажиллуулахаар болсон байна. Монгол Улсын Ерөнхий сайдын баталсан Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурагдсанаас хойш зургаан сарын хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 14 төрлийн ажлыг тусгасан байна.

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн нийгэмлэгийн хооронд байгуулах “Малын индексжүүлсэн даатгал төсөл”-ийн нэмэлт Санхүүжилтийн хэлэлцээрийн болон Хөгжлийн зээлийн шинэчилсэн хэлэлцээрийн төслийг Засгийн газрын (2009.11.18) хуралдаанаар хэлэлцэж, эдгээр төслийг зарчмын хувьд дэмжиж УИХ-ын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон байна. УИХ-ын холбогдох Байнгын хорооноос дэмжсэн шийдвэр гарсны дараа эдгээр хэлэлцээрт гарын үсэг зурах бүрэн эрх олгох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг ажлын журмаар гаргахаар тогтсон байна.

Хүний хөгжил сангийн тухай хуулийг Улсын Их Хурлын (2009.11.18) нэгдсэн хуралдаанаар баталж, 2009.11.18-ны өдрөөс дагаж мөрдөхөөр журамласан байна. Энэ хууль нь 6 бүлэг, 26 зүйлээс бүрдсэн байна. Эл хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг тус тус баталсан байна.

Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай Засгийн газрын (2009.11.19) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 2009 оны 349 дүгээр тогтоолыг гаргасан байна. Энэхүү тогтоолоор Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавиргын боомтоор оруулж буй автобензины тонн тутамд 90 болон түүнээс дээш октантай бол 10,000 төгрөг, дизелийн түлшинд 49,000 төгрөг; Ханх, Ульханмайхан боомтоор оруулж буй автобензины тонн тутамд 90 болон түүнээс дээш октантай бол 10,000 төгрөг, дизелийн түлшинд 49,000 төгрөг; Сүхбаатар, Замын Үүд, Эрэнцав, Алтанбулаг боомтоор оруулах автобензины тонн тутамд 90 болон түүнээс дээш октантай бол 60,000 төгрөг, дизелийн түлшинд 65,000 төгрөгийн онцгой албан татварыг 2009.11.20-ны өдрөөс эхлэн ногдуулахаар тогтоосон байна.

“Банк байгуулах саналын тухай” тогтоолын төслийг Засгийн газрын (2009.11.19) хуралдаанаар хэлэлцэж, банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангаж, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор “Зоос” банкин дахь төрийн зарим мөнгөн хөрөнгөөр төрийн өмчийн банк байгуулах тухай Олон улсын санхүүгийн байгууллагуудын зөвлөмж, Сангийн яам, Монголбанкны саналыг үндэслэн Засгийн газрын тогтоол гаргахаар болсон байна. Мөн “Зоос” банкны бүтцийн өөрчлөлтийг хийхэд шаардагдах 100.0 хүртэл тэрбум төгрөгийн Засгийн газрын бонд гаргах асуудлыг Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 16<sup>1</sup>-д заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэхээр тогтсон байна.

Банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангаж, хадгаламж эзэмшигч-дийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн

5 дахь хэсэг, Банкинд дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийг үндэслэн Засгийн газрын (2009.11.19) тогтоолоор “Зоос” банкинд дахь төрийн зарим мөнгөн хөрөнгөөр төрийн өмчийн банк байгуулах тухай Монголбанк, сангийн яамны саналыг зөвшөөрч, үүсгэн байгуулагчаар Сангийн яамыг томилсон байна. Түүнчлэн шинээр үүсгэн байгуулах төрийн өмчийн банкны дүрмийг батлах; Монголбанктэй зөвшилцсөний үндсэн дээр үүсгэн байгуулах төрийн өмчит банкны дүрмийн санг бүрдүүлж, 2009 оны 11 дүгээр сард багтаан үйл ажиллагааг нь эхлүүлэх; банк байгуулах хүсэлтийг Монголбанкинд гаргаж зөвшөөрөл авах; шинээр үүсгэн байгуулах төрийн өмчит банкны гүйцэтгэх удирдлагыг томилж, тэдгээртэй гэрээ байгуулан, банкны орон тоо, төсвийг баталж мөрдүүлэхийг сангийн сайдад даалгасан байна. Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг хийхэд шаардагдах 100.0 хүртэл тэрбум төгрөгийн Засгийн газрын бонд гаргах асуудлыг Улсын Их Хуралд тавьж шийдвэрлүүлэхийг Сангийн сайдад даалгаж, Монголбанкинд зөвлөсөн байна.

Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Сангийн сайд Засгийн газрын (2009.11.19) хуралдааны үеэр Засгийн газрын гишүүдэд мэдээлэл хийж, үүнтэй холбогдуулан төслийг Улсын Их Хурал дахь МАХН,АН-ын бүлгүүдэд танилцуулахаар тогтсон байна. Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай хуулийн төслийг Засгийн газрын (2009.11.20) хуралдаанаар хэлэлцэж, Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон байна. Хүний хөгжил сангийн тухай хууль (2009.11.19) батлагдсантай холбогдуулан Засгийн газраас санаачлан боловсруулж Улсын Их Хуралд (2009.09.30-ны өдөр) өргөн мэдүүлсэн “Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2010 оны төсвийн тухай” хуулийн төслийг татан авахаар болсон байна.

Засгийн газрын үнэт цаас гарган улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын өргөн барьсан Засгийн газрын үнэт цаас арилжих тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын 2009.11.20-ны өдрийн 77 дугаар тогтоолоор баталсан байна. Үүний дагуу улсын төсвийн алдагдал, эдийн засгийн хямралыг даван туулах зарим арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан 250.0 хүртэл тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас гаргах эрхийг Засгийн газарт олгосон байна.

Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын Хүний хөгжлийн сангийн 2010 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуулиудыг Улсын Их Хурлын 2009.11.27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар тус тус эцэслэн хэлэлцэж баталсан байна. Монгол Улсын 2010 оны нэгдсэн төсвийн нийт орлогыг 2.426.8 тэрбум төгрөг (ДНБ-ний 33.8 хувь), нэгдсэн төсвийн зарлагыг 2.785.4 тэрбум төгрөг (ДНБ-ний 38.8 хувь), нэгдсэн төсвийн нийт алдагдлыг 358.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 5 хувьтай тэнцэх хэмжээнд байлгахаар зөвшөөрсөн байна. Улсын төсвийн 2010 оны хөрөнгө оруулалтын хэмжээг 447.8 тэрбум төгрөг (үүнээс: бүс орон нутгийг дэмжих хөрөнгө оруулалт 73.1 тэрбум төгрөг)-ийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Түүнчлэн өөрийн хөрөнгөөр дараа төлөгдөх нөхцөлтэйгээр 2010 оноос эхлэн хэрэгжүүлэх 229.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг зөвшөөрсөн байна. Улсын төсвийн 2010 оны орлогын төлөвлөгөөнд нэг унци алтны үнийг 900.0 ам.доллар, цэвэр зэсийн үнийг 5800.0 ам.доллар байхаар тооцсон байна. Харин Монгол Улсын 2010 оны төсвийн төсөлтэй хамт Засгийн газрын өргөн мэдүүлсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эдгээр хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах шийдвэр гаргасан байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалт болон Сангийн сайдын 2002 оны 113 дугаар тушаалаар баталсан Буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх журмын 2.1 дэх заалтыг үндэслэн Сангийн сайдын (2009.11.10-ны өдрийн 246 дугаар) тушаалаар Дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх 28 төсөл, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагын жагсаалтыг баталж, эдгээр төслийн хүрээнд нийлүүлэгдэж буй бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Зээл, тусламжийн бодлого, хамтын ажиллагааны газар, Татварын ерөнхий газрын дарга нарт даалгасан байна.

Засгийн газрын 2008 оны 25 дугаар тогтоолоор баталсан Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөрийн 4.3 дахь хэсэг болон Засгийн газрын 2009 оны 333 дугаар тушаалаар Монгол Улсад томуугийн А хүрээний (H1N1) вирусийн халдвар хурдацтай тархаж байгаа учир 2009.11.04-ний өдрөөс эхлэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт 14 хоногийн хугацаагаар шилжүүлсэнтэй холбогдуулан Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайдын (2009.11.11-ний өдрийн 248/149/3721 дугаар) тушаалаар Хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах түр журам, түүний хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаа, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, түүнд шаардагдах төсвийн зардлын хэмжээг Нийгмийн хамгаалал,



хөдөлмөрийн сайдаар батлуулан хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах арга хэмжээ авахыг ажлын хэсэгт даалгасан байна.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хамтран хэрэгжүүлж буй “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төсөл, хөтөлбөр” болон Засгийн газрын 2008 оны 25 дугаар тогтоолоор баталсан Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөрийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын (2009.11.11-ний өдрийн 152/251 дүгээр) тушаалаар Хүнсний талон олгох журам, Хүнсний талон олгосон тэмдэглэл хөтлөх маягт, Хүнсний талон олоор олгох хүнсний бүтээгдэхүүний жагсаалт, Иргэдэд хүнсний талон олгосон тайлангийн маягт, Хүнсний талон олоор худалдан авсан бүтээгдэхүүний үнийн дүнгийн тайлангийн маягт, Хүнсний талоны төлбөрийн тайлангийн маягт, Хөтөлбөрт зарцуулсан хөрөнгийн нэгдсэн тайлангийн маягт, Хүнсний талон олгох, түүгээр хүнсний бүтээгдэхүүн худалдан авахад хамтран ажиллах гэрээний загварыг тус тус баталж, 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөхөөр заасан байна. Түүнчлэн иргэнд сард олгох хүнсний талоны үнийн дүнг 14000 (арван дөрвөн) төгрөгөөр тогтоосон байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 15.2.4 дэх заалтыг үндэслэн Сангийн сайдын (2009.11.13-ны өдрийн 252 дугаар) тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжид хяналт тавих тухай журам, Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж зохиосон аж ахуйн нэгж, байгууллагад олгох гэрчилгээний загварыг баталж мөрдүүлсэн байна. Энэ журам нийтлэг үндэслэл, програмд тавигдах шаардлага, програмыг шалгах, програмын шалгалтын комиссын эрх, үүрэг, гэрчилгээ олгох, програмыг зохиогч, хэрэглэгч талуудын хоорондын үйл ажиллагаа, бусад зүй гэсэн хэсгээс бүрдсэн байна. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 2007 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 38 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжид хяналт тавих тухай журмыг хүчингүй болсонд тооцсон байна.

“Банк байгуулах саналын тухай” Монгол Улсын Засгийн газрын Засгийн газрын 2008 оны 348 дугаар тогтоол, Монголбанкны 2009 оны 652, 653 дугаар тушаалыг үндэслэн төрийн өмчит “Төрийн банк”-ийг 2009.11.26-ны өдрөөс эхлэн байгуулж, түүний дүрмийн сангийн доод хэмжээг 8.0 (найман) тэрбум төгрөгөөр тогтоосон байна. Мөн төрийн өмчит “Төрийн банк”-ны дүрмийг баталж мөрдүүлсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Сангийн сайдын (2009.11.24-ний өдрийн 263 дугаар) тушаалаар Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэх чиглэлээр 2010-2014 онуудад зохиох үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж мөрдүүлсэн байна. Энэхүү төлөвлөгөөнд таван жилийн хугацаанд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хамруулах байгууллага, түүний бүтэц болон хийгдвэл зохих ажлыг он оноор тоймлон тусгасан байна.

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг үндэслэн Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын (2009.11.27-ны өдрийн 407/265/159 дүгээр) хамтарсан тушаалаар Улсын болон хувийн хэвшлийн эрүүл байгууллагаар даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгээр санхүүжүүлэх хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг баталж, 2010 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдүүлэхээр тогтоосон байна. Энэхүү тушаалаар төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний хувьсах зардлын хэмжээг хэвтэн эмчлэх тусламж, үйлчилгээнд 200,000 төгрөг (хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад 100,000 төгрөг), уламжлалт эмчилгээнд 80,000 төгрөг (хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад 80,000 төгрөг), нөхөн сэргээх үйлчилгээнд 50,000 төгрөг (хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад 50,000 төгрөг), өдрөөр эмчлэх тусламж, үйлчилгээнд 114,000 төгрөг, амбулаторийн үйлчилгээнд 9,000 төгрөг, оношилгоо, шинжилгээнд 30,000 төгрөг, хөнгөвчлөх эмчилгээнд 200,000 төгрөг байхаар тогтоосон байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг үндэслэн Сангийн сайдын (2009.11.11-ний өдрийн 249, 2009.11.18-ны өдрийн 256 дугаар) тушаалаар хөрөнгийн үнэлгээ явуулах тусгай зөвшөөрлийн эрх олгох сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр бүхий 49 иргэнд хөрөнгийн үнэлгээ явуулах тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосон байна. Эдгээр тусгай зөвшөөрөл авсан иргэдэд Хөрөнгийн үнэлгээ явуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгож, үүнийг олон нийтэд мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газарт даалсан байна. Сангийн сайдын (2009 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 253 дугаар) тушаалаар хуульд заасан шаардлыг хангасан “Есөн хангай Аудит” ХХК-д, Сангийн сайдын (2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 266 дугаар) тушаалаар “Эс Жи Эм Ди Аудит” ХХК, “Энур Аудит” ХХК-д, аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар тус тус олгосон байна.

Монгол Улсын 2009 оны төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн “Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт” гэсэн 1 дүгээр хавсралтын IY.1 дэх заалт болон Монгол Улсын Тэргүүн шадар сайдын 2009 оны 46, 76, 77 дугаар тушаалыг үндэслэн Сангийн сайдын (2009.11.10-ны өдрийн 245 дугаар) тушаалаар Сангийн сайдын 2009 оны 117 дугаар тушаалын хавсралтаар баталсан Монгол Улсын Шадар сайдын багцад хамаарах “Бүсчилсэн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт”-ын санхүүжилтийн хуваарьт тусгагдсан төсөл, арга хэмжээний 70, 117, 125, 137 – д заасан санхүүжилтийн сарын хуваарийг шинэчлэн баталж, мөрдүүлсэн байна.

Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн “Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт” гэсэн 1 дүгээр хавсралтын IY.2, VII.6 дахь заалт болон Монгол Улсын Тэргүүн шадар сайдын 2009 оны 96, 98, 100, 112, Монгол Улсын Шадар сайдын 2009 оны 46 дугаар тушаалыг үндэслэн Сангийн сайдын (2009.11.24-ний өдрийн 264 дүгээр) тушаалаар Сангийн сайдын 2009 оны 117, 195, 200, 217 дугаар тушаалын хавсралтаар баталсан Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын Шадар сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцад хамаарах Бүсчилсэн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын, Орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын нийслэлд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний, Бүс, орон нутгийг дэмжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хуваарьт 1, 2, 3, 4 дүгээр хавсралтад заасны шинэчлэн баталж мөрдүүлсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны 10 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж, дүнг яамны удирдлага болон олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авлаа:

(1) Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2009 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр 1519.6 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг 40.7 тэрбум төгрөгөөр буюу 2.6 хувиар дутуу биелэгдэж, улмаар 2008 оны мөн үеийнхээс 255.3 тэрбум төгрөгөөр буюу 14.4 хувиар буурсан байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг эх үүсвэрээр нь задлан үзвэл татварын орлогоор 82.1 хувийг, татварын бус орлогоор 16.9 хувийг, тусламжийн орлогоор 0.8 хувийг, хөрөнгийн орлогоор 0.2 хувийг бүрдүүлсэн байна. Улсын төсвийн орлого төлөвлөгөөний биелэлт 10.7 хувиар буюу 133.2 тэрбум төгрөгөөр тасалдахад аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 11.6 хувиар буюу 20.8 тэрбум төгрөгөөр, дотоодын бараа, үйлчилгээний албан татварын орлого 13.5 хувиар буюу 62.5 тэрбум төгрөгөөр, гадаад худалдааны орлого 19.1 хувиар буюу 23.0 тэрбум төгрөг, татварын бус орлого 6.5 хувиар буюу 16.2 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн явдал нөлөөлсөн байна.

(2) Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 2009 оны 10 дугаар сарын батлагдсан төлөвлөгөөгөөр 2065.6 тэрбум төгрөг (үүнээс: улсын төсвийн зарлага 1586.8 тэрбум төгрөг) зарцуулахаас гүйцэтгэлээр 1855.6 тэрбум төгрөг (улсын төсвийн зарлага 1439.2 тэрбум төгрөг)-т хүрч, төлөвлөсөн нэгдсэн төсвийн зарлагын 89.8 хувийг (улсын төсвийн зарлагын 90.7 хувийг) санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн 2008 оны мөн үеийнхээс нэгдсэн төсвийн зарлага санхүүжилт 10.0 тэрбум төгрөгөөр буюу 0.5 хувиар өссөн (харин улсын төсвийн зарлага 2008 оны мөн үеийнхээс 39.7 тэрбум төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн) байна.

Монгол Улсын төсвөөс 2009 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр цалин, тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн олгосон бөгөөд халамжийн сангаас хүүхдийн мөнгөний хөтөлбөрт 30.3 тэрбум төгрөг, шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжид 5.7 тэрбум төгрөг, шинэ гэр бүлд олгох мөнгөн тусламжид 11.3 тэрбум төгрөг, жирэмсэн ба нярай эхчүүдийн тэтгэмжид 13.8 тэрбум төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдийн тэтгэмжид 8.9 тэрбум төгрөг, алдар цолтой ахмадын нэмэгдэл, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөд 5.5 тэрбум төгрөг, ахмад дайчдын орон сууцны дэмжлэгт 3.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын 12.5 хувийг буюу 174.7 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангийн зардалд, 36.7 хувийг буюу 514.9 тэрбум төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, өөрөөр хэлбэл, нийт урсгал зардлын 49.2 хувийг буюу 689.6 тэрбум төгрөгийг цалин, тэтгэвэр, тэтгэмжид зарцууллаа.

(3) Орон нутгийн төсвийн орлого 2009 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр 216.4 тэрбум төгрөгт хүрч, төсвийн орлогын төлөвлөгөөг 5.8 хувиар буюу 11.8 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орон нутгийн төсвийн зарлага 200.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн нийт зардлын 91.6 хувийг санхүүжүүлсэн байна. Улсын төсөвт орон нутгаас 87,802.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 82,748.4 сая төгрөг (Орхон аймаг орлогын төлөвлөгөөг 1,393.7 сая төгрөгөөр давуулан биелүүлж)-ийг төвлөрүүлж, орон нутаг улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 5,054.3 сая төгрөгөөр буюу Булган (550.0), Дархан-Уул (266.9), Өмнөговь (1200.0), Сэлэнгэ (2042.5), Төв (2323.6), Хэнтий (65.0) аймаг орлогын төлөвлөгөөг тус тус тасалдуулсан байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгт 12,565.9 сая төгрөгийг бүрэн олгосон байна.

(4) Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 10 дугаар сарын орлогод зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараар 121.0 тэрбум төгрөг төвлөрсөн (төлөвлөгөө 67.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн) бөгөөд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн зардалд 2009 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр төлөвлөсөн санхүүжилтийн 75.0 хувийг буюу 163.9 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

(5) Нийгмийн даатгалын сангийн орлого 2009 оны 10 дугаар сарын байдлаар 380.0 тэрбум төгрөгт хүрч 4.9 тэрбум төгрөгөөр буюу 1.3 хувиар орлогын төлөвлөгөө давж биелсэн байна. Нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох 128.1 тэрбум төгрөгийн татаасын санхүүжилтийг бүрэн олгож, Нийгмийн даатгалын сангийн зардалд 2009 оны 9 дүгээр сарын гүйцэтгэлээр төлөвлөсөн санхүүжилтийн 100.7 хувийг буюу 364.9 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

(6) Монгол Улсын нэгдсэн төсвийн (өссөн дүнгээр) 2009 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 102.8 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 336.1 тэрбум төгрөгийн алдагдалтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 132.4 тэрбум төгрөгийн, нийт тэнцэл 327.7 тэрбум төгрөгийн алдагдалтай) гарсан байна. Энэхүү алдагдлыг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн эрсдлийн хэсгээс 163.0 тэрбум төгрөгийн, олон улсын байгууллага, хандивлагч улс орнуудаас 206.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Улсын төсөвт байгууллагын төсвийн зарлагын 2009 оны 10 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч нараар нэгтгэн гаргаж мэдээлэв. Улс, орон нутгийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагын 2009 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр өглөг, авлагын мэдээг батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргаж, ОУВС-д хүргүүлээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр (2009.11.01-ний үлдэгдэл) төсөвт байгууллагын төсвийн нийт авлага 6.1 тэрбум төгрөгт, төсвийн нийт өглөг 11.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тухайлбал, улсын төсөвт байгууллагын авлага 5.6 тэрбум төгрөгт хүрч оны эхний үлдэгдлээс 1.3 тэрбум төгрөгөөр буурч, харин өглөг 13.4 тэрбум төгрөгт хүрч оны эхний үлдэгдлээс 9.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Өр, авлагын байдлыг судлан үзэхэд улсын төсвийн байгууллагын авлага өмнөх 2008 оны мөн үеийнхээс 1.6 тэрбум төгрөгөөр буурч, өглөг 4.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, улсын төсвийн орлого 62.0 тэрбум төгрөгөөр буурч, урсгал зарлага 23.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Орон нутгийн төсөвт байгууллагын авлага 0.5 тэрбум төгрөгт, өглөг 1.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Улсын төсвийн байгууллагын авлагын 18.9 хувь буюу 1.1 тэрбум төгрөгийг, өглөгийн 61.2 хувь буюу 8.2 тэрбум төгрөгийг орон нутгийн улсын төсвийн байгууллага үүсгэсэн байна. Нийт өглөгийн 18.4 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн, 21.3 хувийг ашиглалтын тогтмол зардлын, 21.1 хувийг эмийн зардлын, 38.6 хувийг бусад зардлын өглөг эзэлж байна. Нийт өглөгийн байдлыг төсвийн ерөнхийлөн захирагчаар задлан үзүүлбэл: 39.6 хувийг Эрүүл мэндийн сайдын, 28.0 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын, 7.5 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын, 6.7 хувийг Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын, 5.6 хувийг Гадаад харилцааны сайдын, 4.4 хувийг Монгол Улсын Шадар сайдын, 8.3 хувийг төсвийн бусад ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцын байгууллага эзэлж байна.

Батлагдсан төсвийн хуваарийн дагуу улс, орон нутгийн төсөвт байгууллагын 2009 оны 11 дүгээр сарын төсвийн урсгал зардлын эрхийг хянаж, 2009 оны эхний арван нэгэн сарын урсгал зардалд (өссөн дүнгээр) 1,123.2 тэрбум төгрөг (тухайн сард 95.5 тэрбум төгрөг)-ийн санхүүжилт олголоо. Тухайлбал, халамжийн тэтгэвэрт 45,385.1 сая төгрөг (тухайн сард 7,280.1 сая төгрөг), тэтгэврийн нөхөн олговорт 70.0 сая төгрөг (тухайн сард 2.0 сая төгрөг), тэтгэврийн даатгалын сангийн татааст 138,637.4 сая төгрөг (тухайн сард 10,502.0 сая төгрөг), хүүхдийн мөнгөн тэтгэмжид 29,164.6 сая төгрөг (тухайн сард 847.2 сая төгрөг), шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжид 6,330.0 сая төгрөг (тухайн сард 598.5 сая төгрөг), шинэ гэр бүлийн мөнгөн тусламжид 12,413.9 сая төгрөг (тухайн сард 1,127.0 сая төгрөг), жирэмсэн ба нярай хүүхэдтэй эхчүүдэд олгох тэтгэмжид 15,511.0 сая төгрөг (тухайн сард 1,695.0 сая төгрөг), алдар цолтой ахмадын нэмэгдэлд 1,835.5 сая төгрөг (тухайн сард 169.5 сая төгрөг), ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөд 4,095.3 сая төгрөг (тухайн сард 314.2 сая төгрөг), алдарт эхийн одонтой эхчүүдийн тэтгэмжид 8,857.1 сая төгрөг, түүнчлэн эрүүл мэндийн шимтгэлийн төр хариуцах зардалд 7,419.8 сая төгрөг (тухайн сард 674.5 сая төгрөг), сургалтын төрийн сангийн зардалд 24,324.6 сая төгрөг, УИХ-д суудалтай намуудын санхүүгийн дэмжлэгт 3,730.8 сая төгрөг (тухайн сард 100.0 сая төгрөг), Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон нөхөн сонгуулийн зардалд 1,972.6 сая төгрөг, эрчим хүчний алдагдлын зөрүүг нөхөхөд 13,392.2 сая төгрөг (тухайн сард 1,978.5 сая төгрөг), улс, орон нутгийн төсөвт байгууллагын урсгал төсвийн санхүүжилтэд 810,060.1 сая төгрөгийг олгосон болно.

Засгийн газрын нөөц сан, улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хураангуй ба дэлгэрэнгүй тайланг нэгтгэн гаргаж, дүнг долоо хоног тутам удирдлагад тайлагнаж байна. Засгийн газрын шийдвэрийн дагуу 2009 оны эхний 11 сард Засгийн газрын нөөц сангаас 9.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Түүнчлэн 2009 оны эхний 11 сард санхүүгийн дэмжлэгээр орон нутагт 13,171.6 сая төгрөг (тухайн сард 605.7 сая төгрөг)-ийг хуваарилсан байна.

Батлагдсан хуваарийн дагуу 2009 оны эхний 11 сард улсын төсвөөс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 177,209.7 сая төгрөг (тухайн сард 32,973.9 сая төгрөг)-ийн, Монгол Улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2009 оны эхний 11 сард 108,573.7 сая төгрөг (тухайн сард 14,423.8 сая төгрөг), нийтдээ хөрөнгө оруулалтад 2009 оны эхний 11 сарын байдлаар 285,783.4 сая төгрөгийн санхүүжилт олголоо.

Монгол Улсыг хөгжүүлэх санд 2009 оны эхний 11 сарын байдлаар 249.4 тэрбум төгрөгийн орлого (зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараар 152.6 тэрбум төгрөг, хүүгийн орлогоор 3.6 тэрбум төгрөг, 2007 оны улсын төсвийн ашгаас 93.1 тэрбум төгрөг, бусад орлогоор 121.9 сая төгрөг) төвлөрүүлж, харин 0-18 насны хүүхэд хөгжил хөтөлбөрт 86.1 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 108.4 тэрбум төгрөг, улсын төсвийн алдагдлыг нөхөхөд зориулж 219.6 тэрбум төгрөг, улсын нөөц бүрдүүлэлт, ашиглалтын зардалд 5.5 тэрбум төгрөг (нийт 419.6 тэрбум төгрөг)-ийг санхүүжүүлсэн байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн сул чөлөөтэй эх үүсвэрээс Монголбанк, арилжааны банкуудад төгрөгийн ба валютын богино хугацаат хадгаламж байршуулж, түүний хүүд 2009 оны эхний 11 сарын байдлаар 3.1 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нэг бүрийн болон Монголбанкн дахь төрийн сангийн нэгдсэн данс, Хадгаламжийн банкин дахь кассын дансны өдөр тутмын орлого, зарлагын гүйлгээний мэдээг нэгтгэн гаргаж, дүнг удирдлагад танилцуулж байна. Тайлант 2009.11.30-ны байдлаар Монголбанкн дахь төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэл (өмнөх сараас 43.5 тэрбум төгрөгөөр өсөж) 118.8 тэрбум төгрөг, Монголбанкн дахь валютын харилцах дансны үлдэгдэл (өмнөх сараас 2.0 тэрбум төгрөгөөр буурч) 241.2 тэрбум төгрөг, Хадгаламж банкин дахь кассын дансны үлдэгдэл 169.4 сая төгрөг, Санхүүгийн хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 20.1 тэрбум төгрөг, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл (өмнөх сараас 38.3 тэрбум төгрөгөөр буурч) 153.5 тэрбум төгрөг болсон байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслийн хүрээнд зээл олгогч улс орон, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээний дагуу зээлийн төлбөрийг цаг хугацаандаа төлж, хүү торгууль үүсгэхгүй байхад анхааран ажиллаж байна. Өрийн удирдлага, мэдээллийн баазыг шинэчлэн өрийн үйлчилгээний бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг хангаж, Өрийн удирдлагын DMFAS-ийн мэдээллийн баазад 2009 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр (өссөн дүнгээр) 271.2 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалтын мэдээллийг оруулж, дүн мэдээг бүрэн тусгасан байна. Мөн Монголбанкнд өрийн удирдлагын DMFAS програмыг суурилуулан холбогдох эрхийг нээснээр Монголбанк өрийн удирдлагын програмд өдөр тутам ханшны мэдээг оруулж, хувийн хэвшилд олгосон зээлийн нэгдсэн бүртгэл хөтлөх болсон байна.

Засгийн газар 2009 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр гадаад зээлийн үндсэн төлбөрт 71.6 тэрбум төгрөг (тухайн сард 8,673.7 сая төгрөг), хүүгийн төлбөрт 23.7 тэрбум төгрөг (тухайн сард 3,124.9 сая төгрөг), нийт 95.3 тэрбум төгрөг төлсөн байна. Арилжааны банкуудаас дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 2009 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр зээлийн үндсэн төлбөрт 4,720.6 тэрбум төгрөг (тухайн сард 82.7 сая төгрөг), хүүгийн төлбөрт 6,702.5 сая төгрөг (тухайн сард 348.9 сая төгрөг), нийт 11.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Засгийн газрын дотоод зээлийн 2009 оны 11 дүгээр сарын мэдээг гаргаж, төсвийн нэгдсэн тайлан мэдээнд тусгалаа. Тайлант 2009 оны эхний 11 сарын байдлаар Засгийн газрын богино ба дунд хугацаат үнэт цаас (бонд)-ны ашиглалт 243.8 тэрбум төгрөг, буцаан төлбөр 61.5 тэрбум төгрөг, хүүгийн зардалд 2.3 тэрбум төгрөг (үүнээс: Стэнд-бай хөтөлбөрийн хүүгийн шимтгэлд 1.2 тэрбум төгрөг, дотоодын үнэт цаасны хүүгийн зардалд 1.1 тэрбум төгрөг), гадаад бондын ашиглалт 238.5 тэрбум төгрөг (үүнээс: алт хөтөлбөрийн санхүүжилтэд 94.8 тэрбум төгрөг, Айвенхой Майнз ХХК-ийн бондод 143.7 тэрбум төгрөг)-ийн ийн гүйцэтгэлтэй гарсан байна. Засгийн газрын дотоод зээл болох улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон зээлийн буцаан төлөлтөөр (өссөн дүнгээр) 2009 оны эхний 11 сард 2.6 тэрбум төгрөг (тухайн сард 423.1 сая төгрөг)-ийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Засгийн газрын 2009 оны 289 дугаар тогтоолын дагуу Монгол Улсыг хөгжүүлэх сангаас Монгол шуудан банк, Зоос банкинд байршуулсан хадгаламжийг төлүүлэхээр Сангийн сайдын 2009 оны 2/4867 дугаар албан бичгийг Монголбанкнд хүргүүллээ. Үүний дүнд Зоос банкнаас 3.0 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 57.5 сая төгрөгийн хүүгийн төлбөр, 198.7 сая төгрөгийн алдангийг төлүүлсэн байна. Түүнчлэн Монгол шуудан банкаар 158,444.4 мянган төгрөгийн хүүгийн төлбөрийг 2009.11.16-ны өдөр, 8.0 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг 2009.11.19-ний өдөр, мөн 10,222.2 мянган төгрөгийн хүүгийн төлбөрийг 2009.11.20-ны өдөр тус тус төлүүлэх арга хэмжээ авсан байна.

Дэлхийн зах зээл дэх алт, зэсийн үнийн мэдээлийг холбогдох эх сурвалжаас хүлээн авах замаар мэдээлэл боловсруулж, удирдлагад танилцуулан ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан дэлхийн зах зээл дэх алт, зэсийн үнийн төсөөллийг гаргадаг томоохон банк, санхүүгийн байгууллагын үнийн төсөөлийг "Bloomberg"-ийн мэдээллийн эх сурвалжид тулгаварлан судлан үзэхэд нэг тонн цэвэр зэсийн үнийн үнэ 2009 оны эхний 11 сарын байдлаар харьцангуй өсөж дунджаар 5001.4 ам.долларт, харин 11 дугаар сарын дунджаар 6675.0 ам.долларт хэлбэлзсэн байна. Мөн зах зээл дэх нэг унци алтны үнэ 2009 оны эхний 11 сарын байдлаар 959.9 ам.долларт хэлбэлзэж, харин 11 дүгээр сарын туршид алтны үнэ 1100.0 ам.доллараас дээш байснаар 11 дүгээр сарын дунджаар 1127.0 ам.долларт хэлбэлзсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хуулийн дагуу улсын төсөв, орон нутгийн төсөв, нийгмийн даатгалын сангийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсөв гэсэн дөрвөн төрлөөр нэгтгэн гаргаж байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны 8 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг (2009.11.10) нэгтгэн гаргаж, дүнг яамны удирдлага болон Үндэсний статистикийн газар, Монголбанк, ОУВС зэрэг нийт 13 газарт хүргүүлж мэдээлсэн байна.

Монгол Улсын Тэргүүн шадар сайдын ажлын алба, Үндэсний аудитын газар, Усны хэрэг эрхлэх газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Төв аймгийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны хүсэлтийг хянан үзэж, Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудсанд нэвтрэх эрх олгосноор 2009.11.30-ны байдлаар нийт 127 байгууллага нэвтрэх эрхтэй болсон байна. Мөн 2009.11.30-ны байдлаар Худалдан авах ажиллагааны цахим хуудсанд нийт 480 тендерийн урилга нийтлэгдсэнээс 115 тендер шалгаруулалтын үр дүн, 24 тендер шалгаруулалтыг хүчингүй болсон мэдээллийг олон нийтэд зарласан байна.

Сангийн яам, Монголбанкны хамтарсан ажлын хэсэг Алт олборлох үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор арилжааны банкуудтай байгуулсан зээлийн гэрээний хэрэгжилтийн байдлыг Зоос банк, Чингис хаан банк, Голомт банк, Капитрон банк, Худалдаа, хөгжлийн банкинд (2009.11.09-10-ны өдрүүдэд) нэг бүрчлэн танилцаж, түүний дүгнэлтийг Ажлын хэсгийн ахлагч Сангийн дэд сайдад (2009.11.15) танилцуулсан байна.

#### **Эрдэс баялаг, эрчим хүчний талаар:**

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын 2009.11.23-ны өдөр “Шинэ аж үйлдвэржилт-Ажлын байрны баталгаа” сэдвийн дор Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын төлөөлөлтэй уулзалт хийв.

**Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн чиглэлээр:** Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалыг боловсруулж байна.

“Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2009.11.17-ны өдрийн 336/306/300 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.

“Монгол орны 1:500000-ын масштабын ашигт малтмалын эрдсийн хуримтлал бүхий талбайн зураг”-ийн тухай Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2009.11.19-ний өдрийн 301 дүгээр тушаал гарч, Ашигт малтмалын газар хүргүүлэв.

Монгол Улсад зэс хайлуулах үйлдвэр барьж байгуулах боломж, нөхцлийг судлах ажлын хэсгийн санал, дүгнэлт, Дархан-Сэлэнгийн бүс нутагт Металлургийн үйлдвэр байгуулах, Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийн хэтийн төлөвийн асуудлыг тус тус Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, холбогдох үүрэг чиглэлийг өгөв.

Монгол Улсын Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газар, БНСУ-ын Поско компанийн менежмент судалгааны Посри (POSRI) төв хооронд “Монголын төмөрлөгийн үйлдвэрлэл болон түүнтэй холбоотой баялгийг олборлох стратеги бодлого”-ын талаар хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэхэд хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулав.

Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Сангийн сайдын 2009.11.04-ний өдрийн 294/240 дугаар хамтарсан тушаалаар улсын төсвийн хөрөнгөөр 2009 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөг шинэчлэн батлав.

Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн том чадлын дулааны цахилгаан станц барьж цахилгаан экспортлох төслийн явцыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар холбогдох материал, танилцуулга шийдвэрийн төслийг бэлтгэн хүргүүлэв.

**Түлш, эрчим хүчний чиглэлээр:** “Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалыг дахин хянан хэлэлцэж, холбогдох уулзалтыг зохион байгуулан ажиллаж байна.

“Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл дээр ажиллаж байна.

**Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг худалдан борлуулах тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж, санал авахаар Сангийн яаманд хүргүүлэв.**

*“Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2009 оны 284 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан Сангийн яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Төрийн өмчийн хорооны хамтарсан ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж танилцуулав.*

Мянганы сорилтын сангийн Компакт гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төмөр замын төсөлд зарцуулах тусламжийн хөрөнгийг өөр төсөлд шилжүүлэхээр Монгол Улсын Засгийн газраас АНУ, Мянганы сорилтын корпоративтай яриа хэлэлцээр хийж байгаатай холбогдуулан эрдэс баялаг, эрчим хүчний салбараас нийт 70 сая ам.долларын санхүүжилт бүхий **агаарын бохирдлыг бууруулах цогц төслийн** саналыг боловсруулж 2009.04.27, 2009.05.01-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн дэмжүүлсэн. **Төслийн саналыг улам боловсронгуй болгож тус сангийн стандартын дагуу дахин боловсруулах ажлын дагуу АНУ дахь Мянганы сорилтын сангийн Ази, номхон далайн асуудал хариуцсан газрын захирал Кортни, Монголын Мянганы сорилтын сангийн ажилчидтай төслийн эдийн засгийн тооцоо, дотоод үр өгөөжийг дээшлүүлэх нааштай хариу авах зорилгоор хамтран ажилласан. Үүнтэй холбогдуулан Эрдэс баялаг, эрчим хүчний сайд 2009.11.06-ны өдөр АНУ дахь Мянганы сорилтын сангын төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч ноён Блүүмтэй видео уулзсан. Эхний ээлжинд төслийн саналыг 2009.11.17-ны өдөр хөрөнгө оруулагчдын хорооны уулзалтаар хэлэлцэн 47,2 сая ам.долларын санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн.**

ОХУ-ын Роснефть компаниас Монгол Улсад нийлүүлэх газрын тосны бүтээгдэхүүний импортын үнийг 11 дүгээр сард А-80 авто бензинийг 18.0 ам.доллараар, дизелийн түлшийг 28.0 ам.доллараар нэмэгдүүлж, АИ-92 автобензиний үнийг тонн тутамд 22 ам.доллараар бууруулсан. Үүнтэй уялдуулан Сүхбаатар, Замын-Үүд, Эрэнцав, Алтанбулаг боомтоор орж ирж байгаа 90 ба түүнээс дээш октантай автобензинд 40.0 мянган төгрөгийн онцгой албан татвар ногдуулж байсныг 20000 төгрөгөөр нэмэгдүүлэн 2009.11.20-ны өдрөөс эхлэн ногдуулахаар, бусад алслагдсан боомтоор орж ирж байгаа авто бензин, дизелийн түлшинд ногдох онцгой албан татварыг хэвээр нь үлдээхээр Засгийн газрын 2009.11.19-ний өдрийн 349 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлэв.

Агаарын бохирдлыг бууруулах талаар Улсын Их Хурлын 2007 оны 46, Засгийн газрын 2007 оны 218 дугаар тогтоолуудын хэрэгжилт, 2009 онд хийсэн ажлын тайлан, цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлын төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, УИХ-ын Байнгын хороонд хүргүүлэв. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхий сайд УИХ-д агаарын бохирдлын талаар мэдээлэл хийхтэй холбогдуулан Улаанбаатар хотын агаарын бохирдлын өнөөгийн байдал, бууруулах талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашид баримтлах бодлогын талаарх танилцуулгыг бэлтгэн Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн газарт хүргүүлэв.

Баруун бүсийн эрчим хүчний системтэй зэрэгцээ ажиллах **12 МВт-ын хүчин чадалтай Дөргөний усан цахилгаан станц** төслийг түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр барьж байгуулсан БНХАУ-ын Шанхай группээс барилга байгууламжийг **2009.11.20-ны өдөр** Улсын комиссоор ашиглалтад хүлээн авав.

Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хүрээнд Хөвсгөл, Ховд аймгийн төвийн дулааны шугамын шинэчлэл, Хөвсгөл аймгийн Их-Уул, Булган аймгийн Хутаг-Өндөр, Сэлэнгэ аймгийн Баянгол, Төв аймгийн Баянчандмань, Дундговь аймгийн Дэлгэрцогт сумдын халаалтын систем, зуухны шинэчлэлийн ажил, Налайх, Багануурын дулаан станцын шинэчлэл, Дарханы хаалттай системийн шинэчлэлийн ажлыг Улсын комиссоор хүлээн авав.

Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа **“Хөдөөгийн цахилгаан хангамжид сэргээгдэх эрчим хүчийг ашиглах төсөл”**-ийн хүрээнд Нидерландын Засгийн газраас гаргах 4 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр **“20,000 ширхэг нарны цахилгаан үүсгүүр худалдан авах”** олон улсын тендерийн үнэлгээний тайланг Сангийн яаманд хүргүүлээд байна.

Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 8 дугаар сард Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр хийсэн тохиролцоог ажил хэрэг болгох, мөн Казахстаны “КазМунайГаз” болон Монголын “Мон Oil & Gas” компаниудын хооронд 2008.08.30-нд гарын үсэг

зурсан “Казахстанаас Монгол Улсад газрын тос ба газрын тосны бүтээгдэхүүн экспортлох тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн нэгд заасан тохиролцоог хэрэгжүүлэх зорилгоор 2010 оноос газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх асуудлын талаар ярилцаж, тохиролцохоор 2009.11.9-13-ны өдрүүдэд яамны Төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөлөгчид тус улсад ажиллаж, зохих тохиролцоонд хүрэв.

Мөн БНСУ-ын Чечу аралд 2009.11.24-ний өдөр болсон Монгол-Солонгосын эрдэс баялаг, эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагааны дэд хорооны 9 дүгээр хуралд Монголын төлөөлөгчдийг яамны Төрийн нарийн бичгийн дарга ахалж оролцсон бөгөөд хурлын дүнд хоёр тал эрдэс баялаг, эрчим хүчний салбар дахь Монгол-Солонгосын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд тус дэд хороо 1992 онд байгуулагдсанаас хойш ихээхэн үүрэг гүйцэтгэсэнийг харилцан хүлээн зөвшөөрч, хамтын ажиллагааг улам өргөжүүлэн шинэ шатанд хөгжүүлэхээ батлав.

Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос Төв Азийн орнуудын эдийн засгийг дэмжих тусгай программын хүрээнд эрчим хүчний үр ашгийн чиглэлээр 2009.11.02-05-ны өдрүүдэд зохион байгуулсан олон улсын семинарт оролцож Монгол Улсын эрчим хүчний салбарын чадавхи, эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа барилгын салбар дахь эрчим хүчний үр ашгийн төсөл гэсэн сэдвүүдээр илтгэл тавьж харилцан санал солилцов.

УИХ-ын дарга Д.Дэмбэрэл тэргүүтэй төлөөлөгчид 2009.11.21-нд Багануур, Налайх дүүрэгт байрлах салбарын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, тулгамдсан асуудлын талаар харилцан санал солилцов.

2009-2010 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлэв.

Эрдэс баялаг, эрчим хүчний сайд тэргүүтэй албаны хүмүүс 2009.11.13-нд Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрт ажиллаж, тус үйлдвэрийн зэс хайлуулах үйлдвэрийн талаар хийсэн судалгаа, төслүүдийн танилцуулгатай газар дээр нь танилцав.

Төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд 2000 оноос хойш хийгдсэн, хийгдэж байгаа болон хойшид хийхээр төлөвлөж байгаа судалгаа-шинжилгээний ажлын жагсаалтыг бүртгэн авч “судалгаа мэдээллийн бааз” байгуулах ажлыг зохион байгуулж байгаатай холбогдуулан Эрдэс баялаг, эрчим хүчний салбар дахь судалгааны ажлын жагсаалтыг нэгтгэж Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд хүргүүлэв.

Эрчим хүчний үйлдвэрүүдийн үйл ажиллагааны алдагдлын санхүүжилтэд 11 дүгээр сард /”Налайхын дулааны станц” ХК-д 40,0 сая төгрөг, “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ХК-д 69,0 сая төгрөг, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ХК-д 200,0 сая төгрөг/-ийг тус тус олгуулав.

Говь-Алтай, Завхан аймгийн эрчим хүчний үйлдвэрүүд нь “НИК” ХК, “Петровис” ХХК-аас гэрээний дагуу 2009 оны 11 дүгээр сард Говь-Алтай аймгийн эрчим хүчний үйлдвэр 391244,1 литр түлшийг 574,4 сая төгрөгөөр, Завхан аймгийн эрчим хүчний үйлдвэр 446458,4 литр түлшийг 654,7 сая төгрөгөөр тус тус худалдан авсныг хянан үзэж Сангийн яаманд уламжлан санхүүжилтийг олгуулав.

#### **Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын салбарт:**

**Зам, тээврийн чиглэлээр:** ЗТБХБ-ын Сайдын 2009.11.19-ний өдрийн 312 дугаар тушаалаар “Иргэний нисэхийн тухай” Монгол Улсын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалыг боловсруулах, “Тээврийн осол, зөрчлийг шинжлэн шалгах тухай” хуулийн үзэл баримтлал, төсөл боловсруулах ажлын хэсгийг томилсон.

Монгол-Оросын хувь нийлүүлсэн “УБТЗ” нийгэмлэгийн эзэмшлийн 899 орон сууцыг үнэ төлбөргүйгээр сууц эзэмшигчдэд нь хувьчлах асуудлыг Засгийн газрын 11 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж “Орон сууц хувьчлах тухай” Засгийн газрын 338 дугаар тогтоол гарсан.

Автотээврийн газрын даргын 2009.11.09-ний өдрийн 116 дугаар тушаалаар Автотээврийн газраас зарим чиг үүргийг Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт, зохицуулалтын албанд шилжүүлэх ажлыг зохион байгуулав.

Иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх, салбарын бүтцийн өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, иргэний нисэхийн салбарын бүтцийн цаашдын өөрчлөлтийн стратегийг төлөвлөх ажлыг Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны хүрээнд хийлгэх хүсэлт тавив.

**“Төмөр замын зурвас газрыг төсөллөх дүрэм, норм хэмжээ”, “Илчит тэрэг техникийн ерөнхий шаардлага”** стандартуудын төслийг Тээврийн стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлж, дэмжүүлэн Стандартчилал, хэмжил зүйн Үндэсний зөвлөлөөр батлуулахаар хүргүүлээд байна.

Өвлийн улиралд олон улс, улсын чанартай авто замууд болон томоохон даваануудыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд байнгын бэлэн байдалд байлгах зорилгоор шуурхай ажлын хэсгүүдийг 36 цэгт байгуулж, шаардлагатай зардлын төлөвлөгөөг сайдын тушаал гарган батлуулж зохих цэгүүдэд байршуулаад байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа тээврийн хэрэгслийн техникийн хяналт, оношлогооны төвүүдэд 2009.11.16-20 өдрүүдэд хамтарсан шалгалтыг хийлээ.

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал байгуулах төслийн Зөвлөх компанийн 2009 оны IV улирал, 2010 оны ажлын төлөвлөгөөг хянаж Төслийн удирдах хорооны дарга, ЗТБХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж хүргүүлэв.

**“Бодит ажиглалтын систем 3 ширхэг, DVOR/DME тоног төхөөрөмж 4 ширхэгийг худалдан авах, нийлүүлэх, суурилуулах, үүнтэй уялдсан барилга байгууламж, цахилгаан эрчим хүч, авто зам, байгаль орчны үнэлгээ зэрэг холбогдох дэд бүтцийн хамт гүйцэтгэх төсөл”** хэрэгжиж дуусан хүлээж авсантай холбогдуулан тоног төхөөрөмжүүдийг нислэгийн аюулгүй байдал, агаарын зайн багтаамжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр үр дүнтэй, бүрэн ашиглах талаар онцгой анхааран ажиллах, ялангуяа бодит ажиглалтын системийн тусламжтайгаар нислэгийн хөдөлгөөний удирдлагыг агаарын хөлгийн бодит байрлалыг харж удирдах “радар удирдлага”-ын аргачлалд богино хугацаанд шилжүүлэх асуудлыг хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаар ИНЕГ-т албан бичиг хүргүүлэв.

Орон нутгийн зарим буудлыг олон улсын боомт болгох асуудлаар холбогдох яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанд оруулахаар бэлтгэж байна. Ялангуяа Чойбалсан хотын нисэх буудлыг Чойбалсан-Хайлаарын чиглэлд нислэг үйлдэхтэй холбогдуулан эхний ээлжинд шийдвэрлэх шаардлагатай байгаа талаар Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтарсан уулзалтуудыг зохион байгуулсан.

БНХАУ-ын Төмөр замын яамны сайд Лиу Чжи Жунь-д Монгол, Хятад улс хооронд төмөр замаар тээвэрлэх ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөөний биелэлт тасарч байгаа болон манай улсаас экспортолж байгаа нүүрсийг Хятадын тал хүлээж авахгүй байгаа талаар мэдээлж холбогдох арга хэмжээг авч дэмжлэг үзүүлэхийг хүссэн албан бичгийг явуулав.

Зүүн Хойд болон Төв Ази дахь олон улсын холимог тээврийн коридорыг ашиглахтай холбогдуулан нэгдсэн зохицуулалтыг боловсруулах Экспертийн ажлын хэсгийн хуралд оролцож, Монголоор дамжин өнгөрөх тээврийн коридоруудын өнөөгийн байдал, хийгдэж байгаа ажлуудын талаарх илтгэлийг танилцуулав.

**Кувейтийн сангийн зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй Булган-Уньт чиглэлийн 28.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг дуусган ашиглалтанд хүлээн авав.**

**Монгол Улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн 20 км хайрган хучилттай авто зам, Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн 29.05 км, Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 23 км, Хархорин-Хужирт чиглэлийн 21.4 км хатуу хучилттай авто зам, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Турганы голын 96.9 у/м төмөрбетон гүүрүүдийг барьж дуусган ашиглалтанд хүлээн авлаа.**



“Иргэний нисэхийн аюулгүй байдалд сорилт хийх журам”-ыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын Сайдын 2009 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 313 дугаар тушаалаар батлуулав.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам болон Голомт банкны хооронд хамтран ажиллах тухайн харилцан ойлголцлын Санамж бичгийг 2009.11.09-ний өдөр байгуулав.

Томуугийн А хүрээний H1N1 вирусын халдвараас хамгаалах зарим арга хэмжээтэй холбогдуулан гаргасан Улсын онцгой комиссын 2009.10.13-ны өдрийн 03 тоот албан даалгавар, 2009.10.16-ны өдрийн 15 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг, 2009.11.05-ны өдрийн 06 тоот тогтоолоор өгсөн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын “А хүрээний H1N1 шинэ вирусээс хамгаалах зарим арга хэмжээний тухай” 01 тоот албан даалгавар гаргаж салбарын хэмжээний байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин, ЗТБХБ-ын сайдын 295 дугаар тушаал гаргаж орон нутгийн төмөр замын зорчигч тээврийн болон хот хоорондын нийтийн тээврийн хөдөлгөөнийг түр хугацаагаар зогсоох шийдвэр гаргаж хэрэгжүүлэн ажиллав.

**Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлээр:** “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 11.2 дахь хэсэг, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 14.1.4 дахь заалтуудад нийцүүлэн “Үйлчилгээний хөлс тогтоох тухай” Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 82 дугаар тушаалын холбогдох заалтыг 2009 оны 301 дүгээр тушаалаар хүчингүй болгож, уг тушаалыг улсын бүртгэлд бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлэв.

Монгол Улсын Их Хурлаас 2009.07.16-нд баталсан “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай”, “Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль”-д барилгын материалын үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг хамааруулах асуудлыг боловсруулж, “Гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалт”-д нэмэлт оруулан Засгийн газрын 2009 оны 316 дугаар тогтоолоор батлуулж, түүнийг хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг хийж эхлээд байна.

ЗТБХБ-ын Сайдын 2009.11.06-ны 298, 300 дугаар тушаалаар барилга угсралтын 44, зураг төслийн 6 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг сунгаж, барилга угсралтын 26, зураг төслийн 6, барилгын материалын үйлдвэрийн 2 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг шинээр олгох, барилга угсралтын 17 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөлд нэмэлт ажлын төрөл шинээр олгох асуудлыг тус тус шийдвэрлэсэн. Энэ ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл шинээр авах буюу сунгуулахаар шийдвэрлэгдсэн 101 аж ахуйн нэгжүүдийн гэрчилгээг Сайдаар баталгаажуулав.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 182 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах, өөрчлөн байгуулах чиглэл”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Нийтийн аж ахуйн үйлчилгээний хувьцаат компанийн үлгэрчилсэн дүрэм”, “Төрийн болон орон нутгийн өмчит нийтийн аж ахуйн хувьцаат компанийн ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх сангаар дамжуулан хувьцаа эзэмшүүлэх аргачилсан зөвлөмж”, “Компанийн засаглалын бүрэлдхүүн хэсгүүдийн талаархи аргачилсан зөвлөмж”, “Компанийн ёс зүйн дүрэм”-ийг тус тус боловсруулан Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Төрийн өмчийн хорооны даргын 2009.11.18-ны өдрийн 307/326 дугаар хамтарсан тушаалаар батлууллаа.

Засгийн газрын 2006 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн тайланг Сайдын зөвлөлийн 2009.11.05-ны хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулсан.

2009.11.10-нд хуралдсан Салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар Говь-Алтай, Ховд аймгийн 8 сумын төсвийн голлох байгууллагуудын дотор ус хангамж, ариутгах татуурга, гадна шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах судалгааны үр дүн, технологийн хувилбар болон боловсруулсан “Бага оврын цэвэрлэх байгууламжийн төсөл”-ийг тус тус хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.

Шинээр баригдах 14-р хорооллын 6-р хэсгийн дулаан, цэвэр, бохир усны шугам, өргөлтийн насосны станцын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж, ажлыг нь эхлүүлэв.

“Барилгын дулаан хамгаалалт” БНБД 23-02-09/, “Үйлдвэрийн барилга” /БНБД 31-11-09/-ийг боловсруулж Зам, тээвэр барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 314 дүгээр тушаалаар батлуулав.

“Үр хадгалах болон боловсруулах байгууламж” БНБД, “Барилга, замын машин ашиглалтын нэг машин цагийн жишиг үнэ”, “Барилгын технологийн тээврийн автомашины цагийн болон тонкилометрийн жишиг үнэ”, “Барилгын төсвийн суурь норм, хөдөлмөрийн жишиг нормд нэмэлт, өөрчлөлт оруулах”, “Барилгын хийц ба байгууламжийг зэврэлтээс хамгаалах” БНБД-ийн техникийн даалгавруудыг хянаж батлууллаа.

Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн чиглэлээр: Азийн хөгжлийн банк, БНХАУ-ын Сангийн яамтай хамтран 2009.11.02-06-ны өдрүүдэд Шанхай хотод зохион байгуулсан “Тогтвортой хотжилт” сэдэвт бүсийн семинарт ХБГХБГ-ын дарга, мэргэжилтэн нар оролцож туршлага судлав.

“Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөр”-ийн Хотын хөгжлийн бодлогын арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан “Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хөтөлбөрийн судалгаа”-ны ажлыг үндэслэн “Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-нд тодотгол хийх, нийслэл хотын 2030 оны хөгжлийн төсөөллийг тодорхойлох бодлогын шинэчлэлийн биелэлтийн талаарх мэдээллийг 2009.11.06-ны өдөр зохион байгуулсан нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөрийн Удирдах хорооны 2 дугаар хуралд танилцуулсан.

**Баруун бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төслийг** яамны дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурал, Сайдын зөвлөлийн хуралд оруулж танилцуулан, сайдын тушаалаар баталгаажуулахаар шийдвэрлэлээ.

Нийслэлийн 2010 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд яамны бодлогын газрууд, харъяа агентлаг, төслүүдээс санал авч нэгтгэн Нийслэлийн газрын албанд 2009.11.06-ны 8/4395, Нийслэлийн Засаг даргад 2009.11.17-ны 4/4577 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа баруун болон хангайн бүсийн нийт 172 сумын төв, газар тариалангийн кадастрын зураглал ба газрын бүтгэлийн ажлыг гүйцэтгэж байгаа 11 аж ахуйн нэгжийн ажлыг хүлээж авах ажлын хэсгийг 2009.11.20-нд хуралдуулж холбогдох шийдвэрийг гаргав.

Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлөө сунгуулахаар ирүүлсэн долоон аж ахуйн нэгжийн материалтай танилцаж 2009.11.20-нд мэргэжлийн байгууллагын эрх олгох комиссыг хуралдуулан шаардлага хангасан таван аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг сунгав.

**Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр:** “Дорноговь аймгийн Сайншанд суманд баригдах аж үйлдвэрийн цогцолбор байгуулах газрын дэвсгэр зураг хийх ажил”-ын зөвлөхийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2009.11.18-ны өдрийн 277 дугаар тушаалаар байгуулсан.

БНХАУ-ын Засгийн газраас үзүүлж буй хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих “Орон сууцны хорооллын төсөл”-ийн хүрээнд хэрэгжих “Улаанбаатар хотын 7-р хороолол, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн хэрэг эрхлэх газар орчмын инженерийн шугам сүлжээг барих” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2009.11.06-ны өдрийн 261 дүгээр тушаалаар байгуулан тендерийн баримт бичгийг боловсруулж байна.

Тус яамны худалдан авах ажиллагааны шинэчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийт 16 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулан хяналт тавьж ажиллаж байна. Үүнд гэрээ байгуулж ажлаа эхэлсэн 10, ажлын зургаа хийж дуусгаад экспертизээр хянуулж байгаа 1, үнэлгээ хийж байгаа 1, тендерийн баримт бичгийг боловсруулж байгаа 1, ажлын зураг бэлэн болсны дараа тендер зарлах 3 төсөл арга хэмжээнүүд байна. “Аймгийн төвүүдийн орон сууцны инженерийн шугам сүлжээний ажил”-ын хүрээнд орон нутагт нийт 10 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж дуусгав.

Авто замын засвар, арчлалтын санхүүжилтийн гүйцэтгэл оны эхнээс өссөн дүнгээр 81.38% буюу 7,488.0 сая төгрөг /батлагдсан төсөв 9,202.3 сая төгрөг/, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гадаад эх үүсвэрийн гүйцэтгэл

14.87% буюу 4,271.4 сая төгрөг, улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл 60.3 % буюу 78.5 тэрбум төгрөг /батлагдсан төсөв 130.1 тэрбум/-ийг гүйцэтгэгч байгууллагуудын дансанд шилжүүлжээ.

Олон улсын болон улсын чанартай авто замын төлбөр хураах цэгүүдээс 2009.11.23-ны байдлаар оны эхнээс өссөн дүнгээр 774.6 сая төгрөгийн орлого орж, үйл ажиллагааны урсгал зардалд 313.8 сая төгрөгийг, өөрийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтэнд 121.4 сая төгрөгийн, нийт 435.2 сая төгрөгийг батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэгч байгууллагуудад санхүүжүүлэв.

Солонгосын Daewoo компанид төлөх 400 автобусны үлдэгдэл хөрөнгийг барагдуулах талаар 8 компанитай гэрээ байгуулан, хөрөнгийг төвлөрүүлэх арга хэмжээ авч ажилласнаар үлдэгдэл төлбөр болох 2295000 ам.доллараас 1370000 ам.долларыг нийлүүлэгч байгууллагад шилжүүлээд байна

Монгол Улсын Ерөнхий сайдын 2009 оны 4 дүгээр сард БНХАУ-д хийсэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж ГХЯ-нд хүргүүлэв.

Токио хотноо 2009.11.11-12-нд болсон НҮБ-ын Бүсийн хөгжлийн төв (UNCRD) болон Японы Байгаль орчны яамнаас хамтран зохион байгуулж буй **“Хог хаягдлыг багасгах (Reduce), дахин ашиглах (Re-use), дахин боловсруулах (Recycle)”** буюу 3R санаачлагын албан ёсны нээлтийн хуралд тус яамны төлөөлөгч оролцов.

#### **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр:**

Ургац хураалтын 2009 оны дүнг Засгийн газрын 2009.11.18-ны өдрийн хуралдаанд танилцууллаа. Энэ жил улсын хэмжээгээр 392.9 мянган тонн үр тариа, үүнээс 389.1 мянган тонн буудай, 156.0 мянган тонн төмс, 81.4 мянган тонн хүнсний ногоо, 11.1 мянган тонн тэжээлийн ургамал, 4.4 мянган тонн тосны ургамал тус тус хураан авч жилийн хэрэгцээт буудайн 97 хувь, төмсний 100 хувь, хүнсний ногооны 50 хувийг дотоодын ургацаас хангах боломж бүрдсэн байна. Аяны хүрээнд 269.0 мянган га-д уринш боловсруулж бэлтгэжээ.

**“Буудайн урамшуулал олгох тухай”** асуудлыг Засгийн газрын 2009.11.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 350 дугаар тогтоолоор батлуулж, улсад болон гурлын үйлдвэрт тушаасан хүнсний улаан буудайн нэг тонн тутамд 60.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулалт олгохоор тогтоосон байна.

**“Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай”** асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

**Сайдын зөвлөлийн хуралдаанаар** Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр улсын төсөвт тусгагдсан 850.0 сая төгрөг, 30.0 тэрбум төгрөгийн зээл олголтын явцад хийсэн мониторингийн үр дүнгийн тухай хэлэлцүүлэв:

- **Орон нутагт хуваарилагдсан эх үүсвэрээс 2009.11.27-ны байдлаар аймгуудад 1318 төсөлд 15,4 тэрбум төгрөг олгогдож, зээл олголт 95 хувьтай, Улаанбаатар хотод 191 төсөлд 8,7 тэрбум төгрөг олгогдож, зээл олголт 91 хувьтай байна. Нийт 1509 төсөлд 24,2 тэрбум төгрөг олгогдож, зээл олголт 94 хувьтай байна.**
- **Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн төсөл шалгаруулалт, зээл олголтын явцыг эрчимжүүлэх, үйл ажиллагаатай танилцаж, хяналт хийх зорилгоор яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хамтарсан ажлын хэсгүүд батлагдсан удирдамжийн дагуу бүх аймагт ажиллаж дууссан бөгөөд тайланг гаргаж байна.**

**Сайдын зөвлөлийн хуралдаанаар** 2010 оны төсвийн төсөөлөл, Үтрэм, элеваторын аттестатчилал, “Францын Хүнсний тусламжийн сангийн 2003-2008 оны үйл ажиллагаа”-ний хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, тооллогын дүн, “Мал аж ахуй, газар тариалан хосолсон загвар аж ахуйн хөгжлийг дэмжих” төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, “Агропарк” төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, “Усны үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд бэлчээрийн усжуулалтын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл

ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангуудыг хэлэлцэж холбогдох зөвлөмж, тэмдэглэлүүдийг гаргав.

*“Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд мөрдөх техникийн зохицуулалтын төсөл боловсруулах ажлын хэсэг”-ийг Төрийн нарийн бичгийн даргын 2009.11.27-ны өдрийн 357 дугаар тушаалаар байгуулав. Төслийг “Монголын махны холбоо”-той гэрээ байгуулан 2010 оны 2 дугаар сард багтаан боловсруулахаар шийдвэрлээд байна.*

*“Уур амьсгал, байгаль цаг уурын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдлийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд бууруулах талаар хамтран ажиллах санамж бичиг”, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсрууллаа.*

*“Монгол мал хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж УИХ-ын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Байнгын хорооны ажлын хэсэг болон УИХ-ын гишүүдтэй хамтарсан хэлэлцүүлэгт оруулахад бэлэн болгоод байна.*

*“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг 2010 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд холбогдох газар, агентлагуудаас санал авч батлуулахад бэлэн болгов.*

Бэлчээрийн төлөв байдал, даацад үнэлгээ хийх аргачлалыг Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн болон холбогдох Төрийн бус байгууллагуудын мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж эхлээд байна.

*“Мал аж ахуй, газар тариалан хосолсон аж ахуйг нэвтрүүлэх үйлчилгээгээр дэмжин хөгжүүлэх стратегийн төлөвлөгөө”-г боловсруулан Сайдын 2009.11.19-ний өдрийн 260 дугаар тушаалаар батлуулав.*

*“Хүнсний буудайн нөөц бүрдүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан яамдаас санал авч байна.*

**Үндэсний үйлдвэрийг дэмжих дэд хөтөлбөрийн** төслийн эхний хувилбарыг боловсрууллаа.

*“Ноос” дэд хөтөлбөрийг ХХААХҮ-ийн сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж, дэмжигдсэн ба хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулаад байна.*

*“Буудайн гурил техникийн ерөнхий шаардлага” стандарт, “Архи, спиртийн техникийн ерөнхий шаардлага” стандартын төслүүдийг боловсруулж Стандартчилал, хэмжилзүйн газрын “Стандартчилалын Үндэсний зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулав.*

Кремтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тавигдах техникийн зохицуулалтыг боловсруулах ажлын хүрээнд **“Бялуун бүтээгдэхүүний техникийн ерөнхий шаардлага”** стандартыг шинэчлэн боловсруулж холбогдох байгууллагуудаас санал авч байна.

Хүнсний үйлдвэрлэлд ашиглаж буй хүнсний нэмэлтүүдийн чанар аюулгүй байдалд УМХЕГ, Хүнсчдийн холбоотой хамтран шалгалт явуулж, судалгаа гарган **“Хүнсний нэмэлт бодисыг улсын бүртгэлд бүртгэх, хяналт тавих”** журмын төслийг УМХЕГ-тай хамтран боловсрууллаа.

**Инновацийн дэд хөтөлбөрийг** боловсруулж сайдын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхэд бэлэн болгов.

*“Өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар”-ын дагуу 22 аймаг, нийслэлээс өвөлжилтийн бэлтгэл хангасан дүнг авч нэгтгэн Ерөнхий сайдын энэ оны 69 дүгээр захирамжаар байгуулагдсан 2009-2010 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаанд танилцуулан цаашид авах арга хэмжээний хүрээнд **цаг хүндэрч байгаа 6 аймагт Засгийн газрын ажлын гурван хэсэг томилогдон ажиллалаа. Мөн Ерөнхий сайд отор нүүдлийн маргаантай байгаа нутгуудтай танилцаж, Төв, Дундговь, Өвөрхангай, Булган***

**аймгуудийн удирдлагуудтай газар дээр нь уулзалт зохион байгуулж холбогдох арга хэмжээнүүдийг авах үүрэг өглөө.**

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны отрын бүсүүдийн орон тооны бус зөвлөлийн шийдвэрийн үндэслэн АДОБАЗахиргаатай гэрээ байгуулсан 9 аймаг, 23 сумдын отрын 240.8 мянган малыг, аймаг дундын отрын бүс нутгуудад хүлээн авч, хороо, хонд, бууц, худаг, уст цэг хувиарлж, мал өвөлжүүлэх ажлыг зохион байгуулав. **Отроор өвөлжихөөр нүүдэллэн ирж байгаа нийт 410 малчин өрхийн, өрхийн гишүүд, мал сүргийн талаархи судалгааг нарийвчлан гаргаж, мал өвөлжилт, малчдын нийгмийн асуудлын мэдээлэлд хамруулж, харъяалах аймаг сумдаас гэрээнд заасны дагуу шаардлагатай арга хэмжээ авах, болон хүн мал эмнэлэг худалдаа үйлчилгээнд хамруулах талаар хяналт тавьж ажиллаж байна.**

Аймаг дундын отрын бэлчээрт өвөлжиж, хаваржих мал сүргийг эрсдэлээс хамгаалах тэжээл үйлдвэрлэх, нөөцлөх тэжээлийн үйлдвэрийг Жаргалантаас Баянчандмань суманд шилжүүлэн байршуулсны зэрэгцээ ОХУ-д үйлдвэрлэсэн өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмжөөр сольж, үйлдвэрлэлийн ажилд шаардлагатай тэжээлийн будаа, бусад түүхий эдийн асуудлыг шийдвэрлэж, тэжээл үйлдвэрлэлийн ажлыг эхлүүлээд байна.

Ядарч доройтсон малд зориулсан нэмэгдэл тэжээлийг гарын доорх материалыг ашиглан бэлтгэх, түүгээр мал тэжээх арга, технологи сэдвээр цуврал хичээлийг холбогдох газар, эрдэм шинжилгээний байгууллагаар бэлтгүүлэн тэдгээрийг хэвлэл мэдээлэлийн зарим байгууллагатай гэрээ хийж олон нийтэд сурталчилах арга хэмжээг зохион байгуулж, амьтны гаралтай болон гар тэжээл бэлтгэх арга технологи, тэжээх аргачлалын тухай радио хичээлийг зайн сургалт хэлбэрээр малчдад заах хичээлийн төлөвлөгөө гаргав. Мөн монголын радиогийн “Гурван эрдэнэ” студитэй зайн сургалт хийх гэрээ байгууллаа.

Улсын хэмжээний бэлчээр, тариалан, хадлангийн газрын талбайн хэмжээг тус бүрийн ангиллаар сүүлийн 3 жилийн байдлаар аймаг, сум бүрээр гарган мэдээллийн санд оруулахад бэлтгэв. **Бэлчээрт ашиглагдаж буй нийт худгийн тоо, шинээр ашиглалтад орсон худгийг төрлөөр нь аймаг, сумдаар гаргаж сүүлийн 3 жилд барьж байгуулсан худгийн зураглалыг аймаг болон улсын хэмжээгээр гаргав. Мөн 2009-2010 оны мал өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурваст өвөлжүүлэх малын тоо, байршлыг харуулсан зураглал үйлдэв.**

Улсын төсвийн хөрөнгөөр Баянхонгор,Төв, Хэнтий, Дорноговь, Булган, Сүхбаатар, Ховд аймагт шинээр гаргасан худгийн ажлын гүйцэтгэлийг хянаж, санхүүжилт олгох ажлыг зохион байгуулав.

Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг 2009 онд хэрэгжүүлэх ажлын хүрээнд үлийн цагаан оготной тэмцэх ажлыг 405,0 мянган га-д, царцаатай тэмцэх ажлыг 60,6 мянган га-д, бүгд 465,6 мянган га талбайд гүйцэтгэж, улсын төсвөөс нийт 1,3 тэрбум төгрөгийг зарцуулсан болно. **Үлийн цагаан оготной 9 аймгийн 61 сумын 405,0 мянган га бэлчээрийн талбайд гүйцэтгэж, энэ арга хэмжээнд 1 тэрбум төгрөг зарцуулсан . Үүнээс: энгийн механик аргаар 250,0 мянган га, микробиологийн аргаар 100,0 мянган га, авиахимийн аргаар 55,0 мянган га талбайд тус тус оготной тэмцэх ажлыг гүйцэтгэж, царцаатай химийн аргаар тэмцэх ажлыг 2 аймгийн 12 сумын 60,6 мянган га бэлчээрийн талбайд гүйцэтгэж, энэ арга хэмжээнд 309,5 сая төгрөг зарцуулсан байна.**

Мал эмнэлэг, үржлийн газартай 2009.11.2-3 нд нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 16 малын эмийн сангийн үйл ажиллагаатай танилцаж, ажил төрлийн талаар холбогдох хууль, мэргэжлийн зөвлөгөө өгч 5 асуудал бүхий зөвлөмж гаргаж, бүх эмийн сангуудад хүргүүлэв.

**“Хадлан тэжээл-2009”** уралдааны болзлыг дүгнэж, 2 аймаг, 2 сум, 3 аж ахуйн нэгж , 6 малчныг шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнав.

Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийн стандартын үзлэгт мал эмнэлгийн 622 нэгж, мал эмнэлэг, үржлийн 117 нэгж хамрагдан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах хугацаатай үүрэг өгч ажиллалаа.

Үйлдвэржүүлэлтийн жилийн хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр улсын төсвөөс хуваарилсан 30 тэрбум төгрөгийн хүрээнд орон

нутагт хийгдэж буй ажил, түүний үр дүн, явцын талаар Монгол Улсын Тэргүүн шадар сайд, ХХААХҮЯ-ны удирдлагууд бүх аймгийн Засаг нартай хийсэн теле уулзалтыг зохион байгуулав.

*“Арьс ширний үйлдвэрийн технологийн хаягдал усыг цэвэрлэх байгууламжийн талаар, цаашид авах арга хэмжээ”* асуудлаар Нийслэлийн Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс, Ус сувгийн удирдах газрын хамтарсан уулзалт зохион байгуулав. Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2009.10.02-ны өдрийн 171 тоот тушаалаар байгуулсан Ажлын хэсэгт ажиллаж, “Харгиа” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах ажлыг зохион байгуулж, Арьс ширний үйлдвэрийн технологийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагын харьяанд шилжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Арьс ширний үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд Чанарын удирдлагын тогтолцоо /ISO 9000/, Байгаль орчны удирдлагын тогтолцоо /ISO 14000/ стандартуудыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сурталчилгааны материалыг бэлтгэж боловсруулсан ба холбогдох мэдээллийг үйлдвэр, аж ахуйн газруудад электрон хэлбэрээр хүргүүлээд байна.

**“Хүнсний баталгаат байдал”** үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж Үндэсний зөвлөлийн гишүүдээс санал авч нэгтгэв. Тус төслийг Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэлийг хангаж байна.

Дүнсэн тамхины стандартын төслийг боловсруулж, ХХААХҮ-ийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 226/302 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан тамхины стандартын төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдээс цахим сүлжээгээр санал авч байна.

“Атар -50” жилийн ойн арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж, дурсгалын зүйлс, шагналуудыг аймгуудад хүргүүлэв.

Засгийн газрын 2008.12.17-ны өдрийн 58 дугаар тогтоолоор батлагдсан *“Монгол Улсыг хөгжүүлэх санд нөөц хэлбэрээр байршуулах хүнсний буудайг хадгалах байршил, түүнд байршуулах хүнсний буудайн хэмжээг тогтоох, худалдан авах, борлуулах, хадгалах үйл ажиллагааг зохицуулах журам”*-ыг хэрэгжүүлэх, ургац хураалтын ажлыг эрчимжүүлэх, 2010 оны тариалалтад хүрэлцэхүйц хэмжээний үр нөөцлүүлэх, өр авлага барагдуулах зорилгоор Монгол Улсыг хөгжүүлэх санд хүнсний буудай авах ажлыг хэрэгжүүлэхээр ажлын 7 хэсэг гаргаж УМХГ-тай хамтран орон нутагт 2 сарын хугацаанд ажиллаж ТЭДСангийн харъяа Сэлэнгэ, Хөтөл, Хархорин, Булган салбарууд болон Дарханы ГТҮ, Хөвсгөл, Хэнтий нийт 123.7 мянган тонн буудай хүлээн авлаа.

Тариалан эрхлэлтийг дэмжих санд буудай нийлүүлсэн аж ахуйн нэгж, иргэдтай тооцоо нийлж, өр авлагад 54.7 мянган тонн буудайг авсан урьдчилсан дүн гарч байна. Мөн энэ жилийн ургац тээврийн үйлчилгээ үзүүлсэн тээврийн 7 байгууллагатай тооцоо нийлж, гэрээгээ дүгнэх ажлыг гүйцэтгэж байна. Нийт 2.5 тэрбум төгрөгийн үйлчилгээ үзүүлж ургацыг цаг тутамд саадгүй тээвэрлэх арга хэмжээг авлаа.

Төрийн өмчийн услалтын системийн барилгын ажилд гүйцэтгэгчийн тендер зарлаж, гүйцэтгэгчийн тендерт шалгарсан 5 аж ахуйн нэгжийн барилга угсралтын ажлыг хүлээн авах техникийн болон улсын комисс ажиллуулж эхлээд байна.

Монгол Улс, БНЧУ-ын Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд оролцож, салбарын чиглэлээр малын ээмэгжүүлэх хамтарсан үйлдвэр байгуулах боломжийг судлах асуудлыг хуралдаанаас гарах Протоколд тусгуулав. Уг хуралдаанаар Чехийн тал эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллах чиглэлээ тогтоогүй тул *“арьс ширний үйлдвэрийн технологийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийн техник, технологийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх”* саналыг хэлэлцүүлсэн боловч ЗГХКХ-аас гарах Протоколд тусгаагүй болно.

ХБНГУ-ын Ханувер хотноо 2009 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан **“Агритехника”** хөдөө аж ахуйн машин техникийн үзэсгэлэнд Монгол Улсыг төлөөлөн оролцох төлөөлөгчдийн бэлтгэл ажлыг ханган, зохион байгуулав. Үзэсгэлэнд Монголын талаас УИХ гишүүд болон ХХААХҮЯ-ны төлөөлөл, бизнес нийт 10 гаруй төлөөлөгчид оролцов.

БНХАУ-ын Шанхай хотноо 2009.11.16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын Бүсийн чуулга уулзалт”-д оролцож, тус байгууллагын Ерөнхий захирал болон холбогдох албаны хүмүүстэй уулзан цаашид хамтран ажиллах асуудлаар тохиролцов. Үүнд: ДМАЭМБ-аас Монгол Улсыг шүлхий өвчнөөс чөлөөт статус авахад дүгнэлт хийх мэргэжилтэн болон GAP шинжилгээ хийх шинчээгдийн багийг урих талаар ярьж тохиролцов.

*“Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон БНХАУ-ын Тяньжин хотын Дунжяны гаалийн баталгаат боомттой байгуулах санамж бичиг”-ийн төслийг боловсруулан орчуулж хятадын талд, “ХХААХҮЯ болон АНУ-ын Хөдөө аж ахуйн департаменттай хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг”-ийн төслийг боловсруулан орчуулж АНУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ-аар дамжуулан АНУ-ын Хөдөө аж ахуйн департаментад тус тус хүргүүлэв.*

### **Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:**

Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсийг боловсруулж, үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлууллаа.

Ан агнуурын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлт, холбогдох яамдын саналыг тусгаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалын төслийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлээд байна.

“Экологийн хохирлыг тооцох талаар авах зарим арга хэмжээний тухай” Байгаль орчны сайдын 2008 оны 103 дугаар тушаалыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 301 дугаар тушаалаар шинэчлэн баталгаажуулж экологийн хохирол тооцох итгэмжилэгдсэн байгууллагаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Хэрэг бүртгэх газар, Ойн газар, Усны газар, Улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаадыг нэмж тусгав. Түүнчлэн Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт хохирогч, иргэний нэхэмжлэгчээр сум, дүүрэгт тухайн сум, дүүргийн Засаг дарга, нийслэлд 2-оос дээш дүүргийн нутаг дамнасан бол нийслэлийн Засаг дарга болон Байгаль хамгаалах газар, аймагт 2-оос дээш сумын нутаг дамнасан бол аймгийн Засаг дарга болон Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Улсын тусгай хамгаалалттай газар нутагт тухайн газрын хамгаалалтын захиргаа байхаар зааж өглөө.

**Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө 3-ыг баталж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт 15 -ыг гаргаж, 8 төслийн нарийвчилсан үнэлгээний тайланг хэлэлцэж, амьтны тусгай зөвшөөрөл 1-ийг олгосон байна.**

*Хөвсгөл, Мөнххайрхан, Улаан тайг, Тэнгис-Шигшээдийн ай сав, Их Онгог-Булган гол, Хантай, Зэд, Бүтээлийн нуруу, Жаран Тогоон талыг улсын тусгай хамгаалалтад авах болон өргөтгөх асуудлаар хээрийн судалгаа, шинжилгээний ажлыг хийж тусгай хамгаалалтад авах үндэслэл шаардлагыг боловсруулж байна.*

*Увс нуурын ай сав, Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газар, Богдхан уулын дархан цаазат газар, Говь гурван сайхан, Мянган угалзатын нуруу болон Дарьгангын байгалийн цогцолборт газар, Хангайн нурууны байгалийн цогцолборт газар, Хорго-Тэрхийн цагаан нуурын БЦГ зэрэг 7 газрын менежментийн төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж, цаашид менежментийн төлөвлөгөөг батлах эрхийг Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга А.Намхайд олгов.*

2009 онд улсын төсвийн хөрөнгөөр ойжуулах, байгалийн сэргэн ургалтын дэмжих ажилд 120 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нөхөрлөл оролцож 7810.9 мянган ширхэг тарьц, суулгац тарьж ургуулжээ.

Улсын хэмжээгээр 4740 га-д ойжуулалтын ажил хийсэн нь дунджаар 75.04 хувийн амьдралттай тооллогджээ. Энэ нь төлөвлөсөн хэмжээнээс 454 га-гаар буюу 8.7 хувиар тасалдсан дүнтэй байна.

Байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлыг 1130 га-д төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл нь 1053 га буюу 93.1 хувийн биелэлттэй байгаа бөгөөд 6.9 хувиар тасалдсан дүн гарчээ. Энэ нь тарьц, суулгацны хангамж, хүрэлцээ муу байснаас шууд шалтгаалсан гэж үзэж байна.

Мод бэлтгэл явуулдаг аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр нийт 1576.3 га-д ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэснээс Сэлэнгэ аймагт 1209.3 га, Булган аймагт 160 га, Төв аймагт 140 га, Дархан-Уул аймагт 67 га талбайд тус тус гүйцэтгэсэн байна.

Хөвсгөл, Ховд, Говь-Алтай, Дархан-Уул, Дундговь, Завхан, Өмнөговь, Орхон, Хөвсгөл, Говьсүмбэр, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар болон Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүд нь ойжуулалтын төлөвлөгөөт ажлыг бүрэн хийж, 75-аас дээш хувийн амьдралттай ургуулсан дүнтэй байна.

"Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийн хүрээнд говь, хээрийн бүсийн 14 аймагт 132.4 га талбайд ойн зурвас байгуулах ажлын гүйцэтгэснээс амьдралтын хувь 75 -аас дээш хувийн амьдралттай байна.

Өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгжийн таримал ойг улсын санд худалдан авах журмын дагуу 2009 онд 30 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд Увс аймаг 57 га, Баянхонгор аймаг 0.25 га, Дархан-Уул аймаг 15 га, Булган аймаг 5 га, нийт 77.25 га таримал ойг худалдан авч, түүнд 26401.75 мянган төгрөг зарцуулахаар тооцоо гараад байна.

Увс аймгийн ой бүхий 15 сум ойн менежмент төлөвлөгөөгөө батлуулж, Төв аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар ойн сангийн 62.71 хувь буюу 21779 га ойн санг 12 иргэдийн нөхөрлөл, 3 аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Ховд аймагт 2007-2009 онд байгуулсан ойн зурвасыг орон нутгийн ажилгүй иргэдэд эзэмшүүлэн, түүнээс ашиг орлого олж, ажиллуулж хамгаалуулж байгаа нь маш үр дүнтэй ажил болсон байна.

Ойн түймрээс хамгаалах, хулгайн модтой тэмцэх мэдээлэл, мониторингийн сервер байгуулах тендерийг харьцуулалтын аргаар явуулж Жи-Мобайл ХХК-тэй гэрээ байгуулав.

Усны тухай хуулийн 3 дугаар бүлгийн 26 дахь зүйлийн 1 дэх заалтын дагуу 5 аж ахуйн нэгжийн хэрэгжүүлж буй төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд усны нөөц ашиглах дүгнэлтийг гаргалаа.

Монгол орны рашааны тоо бүртгэл явуулах, паспортжуулах ажлыг гүйцэтгэж, 314 рашаанд 17 үзүүлэлтээр, 8 рашаанд 36 үзүүлэлтээр шинжилгээ хийлгэж байна.

"Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа газрын дорхи усны цооног, худгуудын тооцоог худгийн төрлөөр нь ангилж нэгтгэж, хүн амын усан хангамжинд ашиглагдаж байгаа хатуулаг ихтэй усыг зөөлрүүлэхээр тавигдсан тоног төхөөрөмжүүдийг аймаг, сумаар нь нэгтгэж гаргав.

Увс аймгийн Ус-эрдэнэ ХХК нь 2009 онд 115.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэж төсвийн хөрөнгөөр 14, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр 12 гүн өрмийн худаг ухсан байна. ССТ-Од ХХК нь Сагил сумын Боршоон голын адагт 300 га талбайд, ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний станц 40 га талбайд услалтын систем шинээр барьсан байна. Түргэн сумын нутагт хээр морьт гэдэг газарт 10 га талбай услах хүчин чадал бүхий хөв барьж, Түргэн, Тариалан, Сагил, Ховд, Хяргас, Малчин, Наранбулаг сумуудад 8 булгийн эхийг хашиж хамгаалан хамгаалалтын бүсийн гортиг татаж, байгаль хамгаалах сурталчилгааны самбар байрлуулж, ойролцоо амьдардаг малчдад гэрээгээр хариуцуулан өгч ажиллажээ

Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, "Агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2007 оны 46 дугаар тогтоолын 2 дугаар заалтын 2.6 дахь зүйлийг үндэслэн Сайдын 2009 оны 302 дугаар тушаалаар яамны төвлөрсөн арга хэмжээний зардлаас 30.0 сая төгрөг гаргуулж гал өдөөгчийн тендер зарлуулахаар ажиллаж байна.



Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутагт орших Баянцагааны нурууны Тасархайн даваа, Баянхонгор аймгийн Баянлиг, Өмнөговь аймгийн Гурвантэс, Сэврэй сумдын заагт орших Харын боом гэдэг газруудад газар ухаж, алт олборлож байгаа ноцтой зөрчлийг таслан зогсоох үүрэг бүхий хэрийн пост ажиллуулахад шаардагдах зардлын санхүүжилтийн асуудлыг Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран шийдвэрлэж Өмнөговь аймгийн Засаг даргын нөөц сангаас 1.5 сая төгрөг, Байгаль хамгаалах сангаас 2,4 төгрөгийн санхүүжилтийг хийлээ.

Иргэний нийгмийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж 11 дүгээр сард л гэхэд 10.0 сая төгрөгийг Байгаль орчны иргэний зөвлөлд “Байгаль орчны төлөв байдлыг сайжруулахад ТББ-уудын оролцоо” төсөл хэрэгжүүлэхэд, 9.6 сая төгрөгийг Байгаль орчны төрийн бус 6 байгууллагод “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай”, “Газрын хэвлийн тухай” хуулиудын хэрэгжилтэд хяналт хийх” төсөл хэрэгжүүлэхэд, 5.0 сая төгрөгийг Гүн галуут нутгийн иргэдийн холбоо ТББ-д “Гүн галуутайн байгаль хамгааллыг сайжруулах” төсөл хэрэгжүүлэхэд, 7.0 сая төгрөгийг Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөний “Усан сан бүхий газрын хилийн заагийг тогтооход зөвлөх үйл ажиллагаа явуулах” төсөл хэрэгжүүлэхэд тус тус зарцуулж, бүгд 31.0 сая төгрөгийн үйл ажиллагааг санхүүжүүлэн гүйцэтгүүлсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 51 тоот тушаалын дагуу “ТББ-аар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний жагсаалт”-ын 2-т заасан усны нөөцийн асуудлын хүрээнд Усны нөөцийн менежментийг боловсронгуй болгох зорилгоор Монголын байгаль орчны иргэний зөвлөлтэй 2009-2012 онд хамтран ажиллах ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

**Аялал жуулчлалын талаар:** Аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоолгохоор хүсэлт гаргасан 4 аж ахуйн нэгжид зохих ангиллыг шинээр тогтоон гэрчилгээ олгож, 8 аж ахуйн нэгжийн ангиллын гэрчилгээнд сунгалт хийв.

30 жилдээ Лондон хотноо зохион байгуулагдсан Ворлд Трэйвэл Маркет /World Travel Market/ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд манай улс 9 дэх жилдээ оролцлоо. **Үзэсгэлэнд Жуулчин, Нью жуулчин, Грэйт Чингис экспедишн, МАТ, Цэрэн турс зэрэг аялал жуулчлалын тур оператор компаниуд оролцож сурталчилгааны ажил явуулав. Үзэсгэлэнгийн үеэр аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, төр болон хувийн хэвшил нягт хамтран ажиллах, хариуцлагатай аялал жуулчлалын үйл ажиллагааг дэмжих чиглэлүүдийг баримтлан ажиллах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг гаргалаа.**

Монгол, БНХАУ-ын хилийн бүсийн аялал жуулчлалыг зохицуулах хурлыг 2009.12.04-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

“Дисковер Монголиа” нэртэй Аялал жуулчлалын гадаад сурталчилгааны танилцуулга сэтгүүл гарган олон улсын үзэсгэлэн яармаг, гадаад сурталчилгаанд ашиглаж байна.

Аялал жуулчлалын мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиудын багш нарыг хамруулсан сургалтыг “Аялал жуулчлалын багш судлаачдын нийгэмлэг” -тэй хамтран зохион байгуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхийн урилгаар БНТУ-ын Байгаль орчин, ойн сайд профессор, доктор ноён Вейсэл Эроглу албан ёсны айлчлал хийв. Айлчлалын хүрээнд, Туркын олон улсын хамтын ажиллагааны агентлагийн хөрөнгөөр Улаанбаатар хотноо байгуулагдсан Найрамдал цэцэрлэгийн үйл ажиллагаанд оролцож, БНТУ-ын Засгийн газрын хөрөнгөөр Орхоны хөндийд байгуулсан музейн ажиллагаатай танилцав. “Монгол улсын БОАЖЯ, БНТУ-ын Байгаль орчин, ойн яамны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурлаа. Тус санамж бичгийн хүрээнд манай 2 яам ой, ус, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх гэсэн 3 үндсэн чиглэлд хамтран ажиллахаар боллоо.

2. Нэгдэн орсон гэрээ, конвенцийн хэрэгжилтийн талаар Байгаль орчны чиглэлээр манай улс нэгдэн орсон конвенцуудын гишүүнчлэлийн жил бүрийн татвар, төлбөр хураамжуудыг бүрэн барагдуулав.

Булган аймгийн Баян нуурыг хамгаалах ажилд 1,5 сая долларын төслийг хэрэгжүүлэхээр Солонгосын Койка-тай тохиролцож, үнэлгээний багтай хэлэлцээр хийв.

## **Хууль зүйн салбарт:**

Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх болон гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай 4 хуулийн төсөл болон Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай УИХ-ын тогтоолын төсөл, Эрүүл мэндийн санхүүжилтийн бодлогын төслийн 2 үзэл баримтлалыг хянаж шийдвэрлүүлсэн.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай 2 хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хооронд байгуулах **"Санхүүгийн салбарыг хөхиүлэн дэмжих-Ипотекийн барьцаат зээлийн системийг дэмжих"** төслийн зээлийн болон санхүүжилтийн хэлэлцээрийн тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Томуугийн А хүрээний вирүсийн халдварын оношлогоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгалын бодисыг импортоор оруулахад нэмэгдсэн өртгийн албан татвараас болон гаалийн албан татвараас чөлөөлүүлэх тухай, Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Засгийн газар хооронд байгуулсан **"Тогтворжилтийн зээл"**-ийн хэлэлцээрийн тухай болон Улаанбаатар хотын Нарантуул Олон Улсын худалдааны төвийн баруун уулзвар болон төмөр зам дээгүүрх гүүрэн гарц барих тухай, Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолын 7 төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл өгсөн.

Авто тээврийн газрын балансад бүртгэлтэй 20 айлын орон сууцыг хувьчлах тухай, Даатгалын салбарын ажилтны тэмдэглэлт өдрийн тухай, Тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох тухай, Буудайн үйлдвэрлэлийг дэмжиж урамшуулал олгох тухай, Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, Засгийн газрын 2004 оны 163 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад нэмэлт оруулах тухай, Орон сууц үндэсний хөтөлбөрийн төсөл батлах тухай, Татварын алданги тооцох хувь хэмжээг тогтоох тухай, Төрийн өмчийг 2009-2012 онд хувьчлах Үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын болон Засгийн газрын шийдвэрийн 16 төсөлд санал өгөх асуудлыг шийдвэрлэсэн.

НҮБ-ын **"Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх"** төсөлтэй хамтран **"Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах хэлбэрийг устгах тухай конвенцийг хэрэгжүүлэх нь"** сэдэвт сургалтыг цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, зарим төрийн бус байгууллагын ажилтнуудыг хамруулан зохион байгуулав.

Хууль тогтоомжийн үндэсний санд шинээр 30 акт бүртгэгдлээ.

Тайлангийн хугацаанд албан болон хувийн хэргээр түр буюу удаан хугацаагаар ирэх гадаадын иргэдэд холбогдох төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүсэлтийг үндэслэн орох-гарах 337, гарах-орох 638, олон удаагийн 428, гарах-3678, дамжин өнгөрөх 32 нийт 5113 гадаадын иргэнд виз олгосон бөгөөд Монгол Улсад амьдардаг цагаач, байнга оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүнд гарах-орох 138, гарах 6, нийт 144 виз олгосон байна.

Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, бүртгэл, хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн болон визийн хугацаа хэтрүүлсэн зэрэг зөрчил гаргасан гадаадын 21 орны 261 иргэнд Захиргааны хариуцлагын тухай хуульд заасны дагуу 45.300.0 мянган төгрөгийн мөнгөн торгууль ногдуулсан байна.

Гадаадын орнуудаас урьсан иргэнээ зохих хугацаанд бүртгүүлээгүй, хууль бусаар хөдөлмөр эрхлүүлсэн, визийн хугацааг хэтрүүлсэн, нуун далдалсан зэрэг зөрчлийн улмаас 436 иргэн, 41 байгууллага, аж ахуйн нэгжид 102.150.0 мянган төгрөгийн мөнгөн торгууль ногдуулан улсын орлогод оруулсан байна.

## **Батлан хамгаалах чиглэлээр:**

Судан Улсын Дарфур дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд **“Цэргийн хээрийн 2 дугаар шатны эмнэлэг”** оролцуулах тухай, **“Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам”**-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслүүдийг сайдын зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлүүлж, яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

*Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус тус эцэслэн хууль санаачлагчид өргөн барихаар ажиллаж байна.*

**“Төрийн батлан хамгаалах бодлогын үндэс”** баримт бичгийн шинэчилсэн найруулгын төслийг сайдын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэн, гишүүд, ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэн баримт бичгийг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барихаар ажиллаж байна.

Яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралдааныг 3 удаа зохион байгуулж, **“Хүрээлэнгийн судлаачдын гүйцэтгэсэн тайланд хийсэн дүгнэлт”**, **“Шинжлэх ухаан, технологийн төслийн явц байдал”**, **Сайдын нэрэмжит бүтээл шалгаруулах тухай”** асуудлуудыг хэлэлцлээ. Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 30 жил, Яамны ШУТЗ-ийн 20 жилийн ойн хүрээнд **“Цэргийн шинжлэх ухааны өнөө ба ирээдүй”** сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2009.11.24-ний өдөр зохион байгууллаа.

Яам, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг орон нутгийн эдийн засаг, нийгмийн бүх салбар дахь гол үзүүлэлтүүдийг Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөний тодотголд тулгуурлан тодотгох, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг даалгаваржуулахад мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажилласны дээр орон нутгийн хамгаалалттай холбогдуулан бүсүүдийн стратегийн үнэлгээнд шаардагдах мэдээллийн сан бүрдүүлэх, шаардлагатай мэдээллийг газрын зурагт буулгах ажлууд үргэлжлэн хийгдэж байна.

ЗХЖШ-ын тайван цагийн бүтэц, зохион байгуулалт, орон тоог боловсронгуй болгох, **“Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл”**-д өөрчлөлт оруулах саналыг тус тус боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 194 дүгээр зарлигаар **“Онц байдал”** зарласан үед ЗХЖШ болон Зэвсэгт хүчний анги, байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ө.Энхтүвшинд хүргүүлсний гадна **“Үндэсний цэргийн стратеги”** баримт бичиг, **“Зэвсэгт хүчний дайчилгааны шинэчилсэн заавар”**, **“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох төсөл”**-ийг тус тус боловсрууллаа.

2008 оны II ээлжээр цэргийн албанд татагдан ирсэн дайчдыг халж, орон нутагт нь хүргэх ажлыг зохион байгуулав. 2009 оны II ээлжийн цэрэг татлагаар эхний ээлжинд Говь-Сүмбэр, Өвөрхангай, Булган, Завхан, Ховд, Увс, Баянхонгор, Хэнтий аймгуудаас татагдан ирсэн 171 иргэнийг Зэвсэгт хүчний ангиудад хуваарилан хүргүүлсний гадна Монгол Улсын Засгийн газрын 2009.11.04-ний өдрийн 333 дугаар тогтоолоор Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан цэрэг татлагын хугацааг түр хойшлуулж, уг тогтоол гарахаас өмнө төв дамжинд ирсэн 90 иргэнийг хувцаслан Зэвсэгт хүчний 013 дугаар ангид түр байрлуулаад байна.

Зэвсэгт хүчний анги, байгууллагуудад 2009.11.16-наас 2009-2010 оны сургуулийн жилийн I үеийн цэргийн сургалт бэлтгэлийг эхлүүлж, сургуулийн салбарт шинэ дайчдын анхан шатны бэлтгэл, сургууль-байлдааны салбарт тасгийн жигдрэлтийг хангах сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллаа.

**Гадаад харилцааны чиглэлээр:**

БНХАУ-ын Бээжин хотноо гарын үсэг зурсан Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээний төслийг Засгийн газраар хэлэлцүүлж, улмаар УИХ-аар соёрхон батлуулахаар УИХ-ын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр төслийн танилцуулга, холбогдох шийдвэрийн төсөлд яамдаас санал аваад байна.

Гадаад бодлогын үзэл баримтлалыг тодотгон шинэчлэх төслийг Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.

2010 оны дээд, өндөр түвшний айлчлалын төлөвлөгөөний төсөл боловсруулав.

УИХ-ын дарга Д.Дэмбэрэл 2009.11.03-ны өдөр Британийн Элчин сайд Б.Диксоныг хүлээн авч уулзан хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

УИХ-ын дарга Д.Дэмбэрэл ОХУ-д хийх айлчлалын тов, хөтөлбөрийн талаар Оросын талд ноотоор мэдэгдэв. Бэлтгэл ажилтай холбогдуулан яамдаас санал авахаар албан бичиг илгээв.

Гадаад харилцааны яамны 2010 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөний төслийг Сайдын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр бэлтгэв.

ДТГ-уудаас хавсран суух, хавсран хариуцах улсуудын хуваарийг шинэчлэх асуудлаар Ерөнхийлөгчийн Тамгын газраас ирүүлсэн албан бичиг хариу бэлтгэв.

Гадаад харилцааны сайд Г.Занданшатар ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд, Улаанбаатар дахь Дипломат корпусын ахлагч Пиус Фишерийг 2009.11.17-нд хүлээн авч уулзав.

Монгол, Японы Засгийн газар, хувийн хэвшлийн 3 дугаар зөвлөлдөх уулзалтыг Токио хотноо зохион байгуулах, Гадаад харилцааны сайд Г.Занданшатар тэргүүтэй төлөөлөгчдийг уг зөвлөлдөх уулзалтад оролцуулах, сайдыг энэ үеэр Японы Ерөнхий сайд, холбогдох яамдын сайд нар болон парламентын төлөөлөгчидтэй уулзуулах асуудлыг японы талд тавьж бэлтгэлийг ханган ажиллав.

Польш, Румын, Болгар, Унгар, Чех Улс болон Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулав.

2009.12.03-нд Лондон хотноо болох “Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт”-ын бэлтгэл ажлыг үргэлжлүүлэн ханган ажиллаж байгаа бөгөөд Монголын талын төлөөлөгчдийг ЭБЭХ-ний сайд Д.Зоригт ахалж оролцох, мөн энэ үеэр хоёр талын уулзалтууд хийх бэлтгэлийг хангаж ажиллав.

БНТУ-ын Байгаль орчин, ойн сайд В.Эроглу 2009.11.04-07-ны хооронд Монгол Улсад айлчлав. Тэрээр Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхтэй хэлэлцээ хийж, Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид 6-ны өдөр, Тэргүүн шадар сайд Н.Алтанхуягт 4-ний өдөр тус тус бараалхсан болно.

ХБНГУ-ын Бундестагийн гишүүн Р.Хэмпелманн 2009.11.02-04-ний өдрүүдэд Монгол Улсад айлчлав. Тэрээр 2-ны өдөр ГХЯ-ны ГХЭЗХАГ-ын дэд захиралтай уулзсан бөгөөд ЗТБХБЯ, ЭБЭЯ, БОАЖЯ-нд тус тус уулзалт хийсэн. УИХ дахь Монгол, Германы бүлгийн дарга Д.Тэрбишдагва түүнийг мөн хүлээн авч уулзав.

Европын Холбооны Бээжин дэх Төлөөлөгчийн газрын дэд тэргүүн ноён М.Пулч Улаанбаатарт 2009.11.04-08-нд ажиллав. Европын Холбооноос Монгол Улстай хамтран ажиллах 2011-2013 оны Үндэсний баримжаалсан хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих 15.0 сая еврогийн өртөг бүхий төслийг хөдөөгийн хөгжил, техник, мэргэжлийн боловсрол, төрийн захиргааны чадавхийг бэхжүүлэх чиглэлээр ашиглахаар урьдчилан тохироод байна.

ЛИГУ-ын Элчин сайд 2009.11.22-25-ны өдрүүдэд Улаанбаатарт ирж ажиллах бөгөөд энэ үеэрээ ГХ-ны сайд, ГХЯ-ны ЕГ, ТДЁГ-ын захирал нартай тус тус уулзах хүсэлт тавьсны дагуу ажиллаж байна.

Европын Холбооны GSP+ хөнгөлөлтийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар Олон улсын конвенциудын хэрэгжилтийг хүргүүлэх ёстой бөгөөд одоогийн байдлаар 6 конвенцийн хэрэгжилтийг хүргүүлээгүй байгаа болно.

ХБНСЮУ-ын задралаас үүссэн тусгаар улсуудад төлөх Монгол Улсын өрийг нэхэмжилсэн тухай Сербийн үндэсний банкнаас ирүүлсэн материалыг Сангийн яам, Монголбанкинд албан тоотор илгээв.

2007 оны 2 дугаар сард Гавана хотноо болсон Монгол-Кубын Засгийн газар хоорондын комиссын 4 дүгээр хуралдаанаар тохиролцсны дагуу Монгол Улсын Засгийн газар БНКУ-ын төлөх өрийг буцалтгүй тусламжийн хэлбэрээр олгох болсныг эцэслэн шийдвэрлүүлэх талаар Батлан хамгаалахын сайд, Монгол-Кубын Засгийн газар хоорондын комиссын монголын хэсгийн дарга Л.Болдод албан бичиг илгээв.

Дорнод аймаг АНУ-ын Виржиниа муж улсын Арлингтон хоттой эгч дүүгийн харилцаа тогтоох хүсэлтэй байгааг илэрхийлж Дорнод аймгийн Засаг дарга Ц. Жанлаваас Арлингтоны захиргаанд илгээсэн захидлыг Вашингтон дахь ЭСЯ-нд илгээв.

Эквадор Улс Монгол Улстай дипломат харилцаа тогтоох хүсэлт тавьсан 1982 оны 10 дугаар сарын 30-нд Монгол Улс Бүгд Найрамдах Эквадор Улстай дипломат харилцаа тогтоосон болохыг нотолсон хариу Нью-Йорк дахь БТГ-аар уламжлан хүргүүлэв.

Монгол, Кубын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг 2010 онд тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Гавана дахь ЭСЯ-нд хүргүүлэв.

Ерөнхий сайдын гадаад бодлогын зөвлөх О.Оч АНУ-ын Үндэсний ардчиллын хүрээлэнгийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалтыг зохион байгуулав.

Чита мужийн засаг захиргаанаас Монголд байгуулахаар санал болгож буй Читийн төлөөлөгчийн газрын статусын талаар санал боповсруулж, Читийн төлөөлөгчийн газар нь дипломат статусгүй тул Гадаад харилцааны яамтай энэ асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах боломжгүй гэдгийг хариу мэдэгдэв.

ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 35 дугаар чуулганд БСШУ-ны сайд тэргүүтэй төлөөлөгчид оролцох бэлтгэлийг хангаж оролцов.

Барселона хотноо 2009.11.02-06-ны өдрүүдэд болсон УАӨ-ийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенцийн талуудын бага хурлын бэлтгэл ажлын хэсгийн сүүлийн хэсгийн уулзалтад бэлтгэж оролцов.

ОХУ-ын БНТув.Улсын Засгийн газрын дарга Ш.В.Кара-Оолын манай улсад хийсэн албан ёсны айлчлалын бэлтгэл ажлыг хангахад оролцов.

Олон улсын иргэний нисэхийн конвенцийн Хавсралт 11-н 3.6.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан *“Санхүүгийн хямралын үед нийгмийн эмзэг бүлгийн боловсролын салбарын үйлчилгээгээр хангах төсөл”*-ийн Буцалтгүй тусламжийн хэлэлцээр, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Дүрмийн 1997 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлуулах асуудлыг НХХЯ-наас Засгийн газрын хуралдаанаар оруулах гэж буйтай холбогдуулан ОУХБ-ын Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн орчуулгыг тус тус хянан баталгаажуулж, холбогдох газарт хүргүүлэв.

Монгол Улсын ЗГХЭГ-т Хятадын талаас олгох компьютер, тоног төхөөрөмжийг хүлээн авах хаягийг англи хэл дээр бэлтгэж Хятадын ЭСЯ-нд ноотоор мэдэгдэв.

Олон улсын эрүүгийн шүүхийн Хохирогчдод туслах Итгэлцлийн сангийн Захирлуудын Зөвлөлд улиран нэр дэвшиж буй Элчин сайд Б.Алтангэрэлийг Япон Улсын Засгийн газраар дэмжүүлэх чиглэлээр ажиллахыг Токио дахь ЭСЯ-нд үүрэг болгов.

Австралийн санаачлан НҮБ-д оруулж байгаа Цөмийн зэвсгийн туршилтыг бүрэн хориглох тухай гэрээний тухай тогтоолын асуудлаар Нью-Йорк дэх БТГ-т чиглэл хүргүүлэв.

Индонезийн Балид болох цацрах тусгалтай зэвсгийн асуудлаарх АНД-н бүс нутгийн бага хуралд оролцох төлөөлөгчдийн талаарх мэдээлэл, чиглэл Нью-Йорк дэх БТГ-т хүргүүлэв.

Олон Улсын Эрүүгийн шүүхийн шүүгчийг сонгох сонгуульд баримтлах чиглэлийг Брюссель дэх ЭСЯ-нд хүргүүлэв.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы үеэр өнгөрсөн жил Газын зурваст болсон мөргөлдөөний асуудлаарх “Goldstone report”-ыг хэлэлцүүлэхтэй холбогдуулан Арабын зарим улсаас санаачилсан тогтоолын төслөөр санал хураалт явагдахтай холбогдуулан яамны удирдлагуудад танилцуулж, холбогдох чиглэлийг Нью-Йорк дахь БТГ-т илгээв.

Манай улс ЮНЕСКО-гийн Гүйцэтгэх зөвлөлийн Тусгай хороо болон Олон улсын төрийн бус байгууллагуудын хороонд нэрээ дэвшүүлж, сонгогдон ажиллах чиглэлийг Парис дахь БТГ-т хүргүүлэв.

Олон Улсын Далайн байгууллагын чуулганы үеэр болох сонгуульд баримтлах чиглэлийг боловсруулан Лондон дахь ЭСЯ-нд хүргүүлэв. **Уг сонгуульд дэмжих шийдвэр гарсан тухай ноотыг УБ дахь Япон, БНТУ, БНСУ, ОХУ, ХБНГУ, Энэтхэгийн ЭСЯ-дад хүргүүлэв.**

Онц хүнд гэмтэл учруулах, үл ялгаварлан хөнөөх чанартайд тооцож болох зарим ердийн төрлийн зэвсэглэлийг хязгаарлах буюу хориглох тухай конвенци болон түүний нэмэлт Протоколуудын хэрэгжилтийн талаарх манай байр суурийг бэлтгэж Женев дэх БТГ-т хүргүүлэв.

**Худалдаа, эдийн засгийн харилцааны чиглэлээр:** Олон улсын Үзэсгэлэнгийн товчооны 146 дугаар Ерөнхий ассамблейн хуралдааны үеэр болох сонгуульд баримтлах чиглэлийн талаар санал боловсруулав.

Монгол Улсад “**зах зээлийн эдийн засагтай улс**” статус олгох асуудлаар үнэлгээ хийх ажлын хэсгийн хөтөлбөрт Европын Комиссын хүсэлтийг харгалзан санхүүгийн салбарын өнөөгийн байдалтай танилцах, хувийн хэвшил болон манай улс дахь олон улсын байгууллагуудын төлөөлөгчийн газартай уулзалт зохион байгуулах зэрэг өөрчлөлт оруулав. Хөтөлбөрийн төслийг Европын Комиссын Худалдааны ерөнхий газарт хүргүүлэхээр Брюссель дэхь ЭСЯ-нд илгээв.

Химийн хорт бодис болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах шинэчилсэн журам батлах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Гадаад харилцааны сайдын хамтарсан тушаал болон журмын төсөлд санал өгөв.

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.10.14, “Тамхины хяналтын тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу “Глобал Бридж”, “Хангалуун трейд” ХХК зэрэг аж ахуйн нэгжээс ирүүлсэн тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан үзээд Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулж, холбогдох яамд, мэргэжлийн байгууллагуудаас санал авахаар хүргүүлээд байна.

**Консулын харилцааны чиглэлээр:** Монгол, Солонгосын консулын IV зөвлөлдөх уулзалтыг Сөүл хотноо 2009.12.14-15-ны өдрүүдэд зохион байгуулахтай холбогдуулан бэлтгэл ажлыг ханган ажиллав.

Дипломат болон албан паспорт эзэмшигчид харилцан визгүй зорчих тухай Хэлэлцээрийн монгол болон молдавын төслүүдийг хянан үзээд саналаа Москва дахь ЭСЯ-нд хүргүүлэв.

Консулын зөвлөлдөх уулзалтын үеэр хоёрдмол харьяаллын асуудлаарх Монгол Улс, БНКаз.У-ын хамтарсан ажлын хэсгийн уулзалт хийх санал тавьсныг дэмжиж, ХЗДХЯ-нд албан бичиг илгээв.

Монгол, Казахстаны консулын зөвлөлдөх уулзалтын бэлтгэлийг хангаж, 2009.11.11-12-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав.

Иргэд харилцан зорчих нөхцлийг хөнгөвчлөх асуудлаар Улаанбаатар дахь Япон Улсын ЭСЯ-ны консулын хэлтсийн ажилтнуудтай ээлжит хэлэлцээ хийж, байр сууриа тайлбарлав.

Монгол Улсаас Япон Улсын Нагоя хотод суух Өргөмжит консулаар Чоносүкэ Андо, Монгол Улсаас Умард Ирландад суух Өргөмжит консулаар Ричард Холмсийг тус тус томилов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар